soil moisture levels were carried over winter to the following spring, and thus may affect the rates of leaf emergence, plant growth and carbon uptake in the early- to mid-growing season. Gross primary production was twice as sensitive as Reco to prolonged dry seasons, leading to a close negative relationship between annual NEP and dry-season length. Annual GPP and NEP were positively correlated with annual rainfall. Negative annual NEP (i.e., the ecosystem being a carbon source) tended to occur when the dry-season length exceeded 50 d yr⁻¹ or annual rainfall dropped below 280 mm yr⁻¹. Annual Rs ranged from 232 to 335 g C m⁻² yr⁻¹, and increased with summer rather than annual rainfall amount. These patterns underscore the influence of precipitation legacy and seasonal variability on the carbon balance of the studied desert shrubland ecosystem.

Total ecosystem respiration increased linearly with GPP at both seasonal and interannual scales, with the slope being 0.50 and 0.55, respectively. Indicators of the seasonal temperature sensitivity, i.e., Q_{10} and the activity energy (E_0), of Reco increased with both the annual integral and seasonal amplitude of GPP. Wavelet coherence revealed synchronized diel cycles in photosynthesis proxies (GPP and PAR) and Rs. The spectral Granger-causality analysis suggested a possible causal linkage between GPP and Rs at the diel scale during the growing season. Significant wavelet coherence was also observed between GPP and Rs at seasonal to annual scales, with Rs lagging GPP by an average of two days. These relationships reveal a tight coupling between photosynthetic carbon gain and respiratory carbon loss, indicating a strong substrate limitation on respiration.

Conclusions and implications:

These findings have important implications for predicting future ecosystem functioning in desert shrublands. First, winter warming and reductions in autumn and winter precipitation may trigger spring droughts, thereby diminishing the carbon sequestration potential of shrubland and steppe ecosystems across semiarid and arid Eurasia. Second, an extended dry season under climate change may further constrain long-term carbon storage in desert shrublands, highlighting the need to prioritize drought-adapted plant species in ecosystem restoration to maintain ecosystem functions. Third, process-based carbon models should explicitly account for the influence of substrate supply (e.g., from GPP) on respiratory CO₂ fluxes and their temperature sensitivities.

Keywords: Dynamics, ecosystem, CO₂ fluxes, shrubland, desert

COUNTERMEASURES AGAINST DESERTIFICATION USING THE BIOLOGICAL SOIL CRUST (BSC) METHOD: PILOT TEST RESULTS IN UMNUGOVI PROVINCE AND THE OUTSKIRTS OF ULAANBAATAR, MONGOLIA

Hideki Imai¹*, Yoshihiro Katsuhama¹, Takahiro Shiono¹, Mineto Tomisaka¹

¹ *Nippon Koei Co., Ltd. (Tokyo, Japan)*

* *Corresponding author: imai-hk@n-koei.jp*

Introduction:

Desertification and land degradation pose serious threats to ecosystems and the sustainability of local communities in the arid regions of Mongolia. Practical technologies that have been validated in the field are urgently required to address these challenges. The Biological Soil Crust (BSC) method, developed in Japan, stabilizes soil using soil algae and promotes vegetation establishment. This study verified its effectiveness through pilot tests conducted in Umnugovi Province and the outskirts of Ulaanbaatar.

Objectives:

- To evaluate the practicality and effectiveness of the BSC method in Umnugovi Province and the outskirts of Ulaanbaatar.
- To clarify its effects on vegetation recovery, soil stabilization, and water retention based on field data.
- To identify the potential and challenges for large-scale application in arid lands including Mongolia.

Methods:

In 2025, pilot tests were conducted on degraded land surfaces with declining vegetation in Umnugovi Province and near Ulaanbaatar. BSC material was sprayed on the ground surface, and treated plots were compared with untreated control plots. No seeds were used in the tests.

Evaluation indicators included:

- Vegetation coverage rate
- Formation of biological soil crust (visual assessment)
- Wind erosion suppression (observations during strong winds)
- Soil moisture content measured through laboratory tests of collected soil samples

Results:

Compared with control plots, BSC-treated plots showed the following improvements:


- Increased vegetation coverage
- Visible formation of biological soil crust
- Suppression of wind erosion and dust generation
- Soil moisture content was measured, but due to heterogeneous soil conditions, further correction and time are required for accurate evaluation.

Discussion and conclusion:

The pilot tests confirmed that the BSC method demonstrated practical effectiveness in the field. Notable improvements were observed in vegetation coverage and surface soil stabilization, indicating its potential as a countermeasure against desertification. Future work will include long-term monitoring, verification across multiple sites, development of improved soil moisture measurement methods, and further accumulation and analysis of ecological data on Mongolian vegetation. For further advancement in Mongolia and international deployment, collaboration among government agencies, private companies, and academic institutions will be essential.

Photographs and graph

*Table 1. Monitoring results after four months
(Comparison between Control Plot and BSC Standard Plot)*

Control (Plot-5)		BSC standard application (Plot-1)	
Vegetation coverage: 17.77 %		Vegetation coverage: 49.83 %	
			
Plot Image	Analysis Image	Plot Image	Analysis Image




Figure 1. Changes in vegetation coverage of each plot (up to four months after monitoring)

Keywords: Biological Soil Crust, desertification control, pilot test, vegetation coverage, ecosystem restoration, Mongolia

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТ, ДОРОЙТЛЫН ҮНЭЛГЭЭ: ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ЦУВРАЛ ӨГӨГДӨЛ БОЛОН ХИЙМЭЛ ОЮУНЫ АРГУУДАД СУУРИЛСАН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Замба Батжаргал¹, Отгонбаяр Мөнхдулам^{2*}, Оргил Анумандал³

¹ Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэн, Улаанбаатар 15160, Монгол

² ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Улаанбаатар 15170, Монгол

³ ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Улаанбаатар 13330, Монгол

*Холбоо барих зохиогчийн цахим хаяг: munkhdulamo@mas.ac.mn

Хураангуй

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь олон эх сурвалжийн хиймэл дагуулын урт хугацааны цуврал өгөгдөл болон хиймэл оюунд суурилсан машин сургалтын дэвшилтэд аргуудыг ашиглан Монгол улсын газрын өөрчлөлт, доройтлыг үнэлэх явдал байлаа. Тус зорилгын хүрээнд Монгол орны нийт нутаг дэвсгэрийг хамарсан 1990-2019 он хүртэлх 30 жилийн олон эх сурвалжийн хиймэл дагуулын болон статистикийн цуврал өгөгдлийг ашиглан уур амьсгал, биофизик болон нийгэм-эдийн засгийн гурван үндсэн хүчин зүйлийн орон зай, цаг хугацааны нөлөөллийг системтэйгээр судалсан. Тухайлбал 1) уур амьсгалын хүчин зүйлсийн (агаарын температур, хур тунадас гэх мэт) урт хугацааны өөрчлөлт, 2) биофизик хүчин зүйлсийн (ургамлын индекс, гангийн индекс гэх мэт) урт хугацааны өөрчлөлт, 3) газрын ашиглалт-газар бүрхэвчийн динамик хандлагыг шинжилж, эдгээр нь газрын өөрчлөлт, доройтлын үйл явцад хэрхэн нөлөөлж байгаа тодорхойлсон.

Аргазүй:

Монголын уудам газар нутгийн өөрчлөлт, доройтолд уур амьсгалын хүчин зүйлсийн үзүүлж буй нөлөөллийг үнэлэхийн тулд уур амьсгал судалгааны төвийн CRU-TS (Climatic Research Unit Time Series) 1990–1999 оны ~50 км (0.5°) орон зайн нарийвчлалтай v4.03, 2000–2019 оны ~1.0 км (30 секунд) нарийвчлалтай WorldClim v2.1 гэсэн хоёр өөр эх сурвалжийн сар бүрийн дундаж температур, сар бүрийн нийлбэр хур тунадасны 30 жилийн өгөгдлийг ашигласан. CRU-TS (~50 км) өгөгдлийн орон зайн нарийвчлалыг WorldClim (~1.0 км)-ийн орон зайн нарийвчлалтай ижилсүүлэхийн тулд “Dynamic downscaling” аргыг ашигласан. Энэ нь уур амьсгалын бүс нутгийн загварт суурилсан физикийн загварчлалаар

том масштабын өгөгдлийг нарийвчилдаг ихээхэн тооцоолол шаарддаг боловч үр дүнтэй арга юм.

Биофизик хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлэхийн тулд ургамлын нормчлогдсон ялгаврын индекс (NDVI)-ийн хоёр өөр эх сурвалжийн өгөгдлийг ашигласан. Үүнд: Дэлхийн Ургамлын Бүрхэвчийн Загварчлал ба Зураглалын Судалгаа (GIMMS– Global Inventory Modeling and Mapping Studies) хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан 1990–2001 оны ~ 8 км (0.07273°) орон зайн нарийвчлалтай 15 хоног тутмын GIMMS NDVI-ийн өгөгдөл болон АНУ-ын Үндэсний Агаар Сансрын Удирдах Газар (NASA)-ын Terra хиймэл дагуулд суурилуулсан MODIS (Moderate Resolution Imaging Spectroradiometer) мэдрэгчийн 250 м орон зайн нарийвчлалтай MOD13Q1 бүтээгдэхүүнээс 2002–2019 оны 16 хоног тутмын NDVI өгөгдлийг тус тус ашигласан. Эдгээр хоёр өгөгдлийн орон зайн ялгааг арилгахын тулд “Statistical downscaling” аргыг ашигласан бөгөөд энэ нь биофизик хүчин зүйлсийн газрын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөг орон зайн болон цаг хугацааны огтлолцолд нарийвчлалтай тодорхойлох боломжийг бүрдүүлсэн.

Харин газар ашиглалт, газрын бүрхэвчийн өөрчлөлтийг илрүүлэхэд 1990, 2019 оны 5–9 дүгээр саруудын 30-ийн орон зайн нарийвчлалтай ландсат 5, ландсат 8 хиймэл дагуулын 6 сувгийн нийт 216 ширхэг өгөгдлийг ашигласан. Лавлагаа өгөгдлүүдийг Дэлхийн газрын бүрхэвчийн нарийвчилсан ажиглалт ба мониторингийн өгөгдөл (FROM-GLC)-ийн сангаас авч ашигласан. Түүнчлэн газрын бүрхэвчийг ангилахад FROM-GLC-ийн 2-р хувилбарын ангиллын системийг ашигласан. Энэ ангиллын систем нь 11 үндсэн ангиллыг агуулсан бөгөөд эдгээр нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын газрын бүрхэвчийн ангилал болон Олон улсын Гео-Биосферийн Хөтөлбөр (IGBP)-ийн ангиллын системтэй уялдуулахад хялбар бүтэцтэй байлаа. Нэмэлт лавлагаа цэгүүдийг өндөр нарийвчлалтай Google Earth хиймэл дагуулын зургуудыг ашигласан тогтоосон.

Дүн шинжилгээнд хиймэл оюуны дэд хэсэг болох машин сургалтын болон параметрийн бус статистикийн аргуудыг хослуулан ашигласан. Үүнд: санамсаргүй ойн ангиллын загвар (Random Forest Classification), хэсэгчилсэн хамгийн бага квадратын регресс (Partial Least Square Regression), Sen-ийн хазайлтын үнэлгээ (Sen’s slope estimator), Mann–Kendall тест, BFAST (Breaks For Additive Season and Trend) алгоритм болон RESTREND (Residual Trend Analysis) үлдэгдлийн чиг хандлагын шинжилгээ зэрэг багтана. Тодруулбал, газар ашиглалт-газрын бүрхэвчийн өөрчлөлтийг илрүүлэхэд санамсаргүй ойн ангиллын загварыг ашигласан бөгөөд энэ багцын статистик арга нь ангиллын өндөр нарийвчлал, хувьсагчийн ач холбогдлыг тодорхойлох давуу талтай. Хоёр өөр эх сурвалжийн ургамлын индексийн орон зайн ялгааг ижилсүүлэхэд PLS регрессийн загварыг ашигласан. Хуурайшлын хандлагыг илрүүлэхэд ургамлын индексийн цуврал өгөгдлөөс гангийн индекс (Drought Index)-ийг тооцсон. Улмаар температур, хур

тунадас, ургамлын индекс, гангийн индекс зэрэг хувьсагчуудын урт хугацааны хандлагыг (тренд) илрүүлэхэд параметрийн бус Sen-ийн хазайлтын үнэлгээний аргын ашигласан. Мөн эдгээр цуврал хувьсагчуудад монотон (өсөх, буурах гэх мэх) чиг хандлага байгаа эсэхийг илрүүлэхэд Mann–Kendall тестийн аргыг ашигласан. Улирлын хэлбэлзэл (seasonality), чиг хандлага (trend), гэнэтийн огцом өөрчлөлтийн (breaks) бүрэлдэхүүн хэсгүүдийг задлан шинжлэхэд BFAST алгоритмыг, харин байгалийн бус хүчин зүйлс (голлон хүний үйл ажиллагаа)-ийн нөлөөгөөр бий болсон газрын өөрчлөлт, доройтлыг илрүүлэхэд RESTREND аргыг тус тус ашигласан.

Үр дүн:

Сар бүрийн дундаж температур 1990-2019 оны цуврал өгөгдлийн шинжилгээгээр жилийн дундаж температур 1.8°C -аар нэмэгдсэн бөгөөд хамгийн дулаан жил нь 2007 онд, хамгийн хүйтэн нь 2012 онд ажиглагдсан байна. 2000, 2006–2008, 2010, 2013–2019 онуудад $+1.0^{\circ}\text{C}$ -ээс дээш температурын хазайлт олонтоо тохиолдсон нь уур амьсгалын дулаарлын эрчимжсэн хандлага байгааг илтгэнэ. Сар бүрийн нийлбэр хур тунадасны 1990-2019 оны цуврал өгөгдлийн шинжилгээгээр жилийн нийлбэр хур тунадас 74 мм-ээр буурсан ч орон зайн хувьд бага зэрэг нэмэгдэх хандлага ажиглагдсан. Хур тунадасны эерэг хазайлт 1990, 1993, 2016 онуудад, харин сөрөг хазайлт 2002, 2017 онуудад ажиглагдсан байна.

Ургамлын индексийн 1990–2019 оны цуврал өгөгдөлд хийсэн Sen-ийн хазайлт, Mann–Kendall тестийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд сөрөг хандлага нь Монгол Алтай, Их нууруудын хотгор, Хангайн нурууны баруун болон баруун өмнөд хэсэг, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутгаар, Дорноговь аймгийн урд болон баруун урд хэсгээр, мөн Хэнтийн нурууны өмнөд зах, Дорнод аймгийн Матад сум орчмын нутгаар илэрсэн байна. Харин эерэг хандлага нь Дундговь, Өмнөговь аймгуудын төв болон хойд хэсгээр, Дорноговь аймгийн хойд хэсгээр нэлээд өргөн талбайд илэрсэн байна.

BFAST алгоритмаар гэнэтийн огцом өөрчлөлт (breakpoints)-ийг илрүүлэхэд, ойн түймэр, уул уурхайн үйл ажиллагаа, хотжилт зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй газруудад бүтцийн хугарлууд тод илэрсэн бөгөөд эдгээр нь Sen's slope болон Mann–Kendall-ийн хандлагын шинжилгээгээр тогтоогдсон статистикийн ач холбогдолтой трендийн өөрчлөлтүүдтэй орон зайн хувьд өндөр давхцалтай байна. Өөрөөр хэлбэл, BFAST алгоритмын дүнгээр илэрсэн ургамал бүрхэвчийн гэнэтийн огцом өөрчлөлт, доройтол илэрсэн газрууд нь Sen's slope болон Mann–Kendall шинжилгээгээр тогтоогдсон трендийн өөрчлөлттэй орон зайн хувьд давхцаж байна.

Газар ашиглалт-газрын бүрхэвчийн өөрчлөлтийн шинжилгээний үр дүнгээр 1990-2019 он хүртэл 30 жилийн хугацаанд ой (-4.14 сая пиксель), хээр (-4.75

сая пиксель), хуурай хээр (−19.66 сая пиксель) болон тариалсан талбайн (−9.93 сая пиксель) хэмжээ багассан, эсрэгээрээ нугын хээр (+32.92 сая пиксель), элс (+3.32 сая пиксель), уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн халцгай (+1.57 сая пиксель), хот суурины газрын (+0.56 сая пиксель) талбайн хэмжээ тус тус нэмэгдсэн байна.

Гангийн индексийн шинжилгээний үр дүнд 1997, 2002, 2005, 2006, 2007 болон 2017 онууд нь хэт хуурай, гантай жилүүд байсан болохыг тогтоосон бөгөөд энэ нь тухайн жилүүдэд бүртгэгдсэн цаг уурын гангийн түүхэн мэдээлэлтэй нийцэж байна. Энэхүү үр дүн нь ургамлын индексийн өгөгдлөөс тооцсон гангийн индекс нь орон зайн болон цаг хугацааны огтлолцолд тулгуурлан гантай үеийг үнэн зөв илрүүлэх боломжтойг харуулж байна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын өөрчлөлт, доройтлыг илрүүлэхийн тулд ургамлын индексийн 1990-2019 оны цуврал өгөгдлийг мөн хугацааны температур, хур тунадас, ууршилтын өгөгдөлтэй хамтатган RESTREND (Residual+Trend) аргачлалаар шинжилсэн. Энэ арга нь уур амьсгалын хүчин зүйлсээр тайлбарлагдах NDVI-ийн тооцоолсон утгыг бодит ажиглалтын NDVI утгатай харьцуулж тэдгээрийн үлдэгдэл (residual) буюу ялгааг тодорхойлох замаар уур амьсгалын суурь нөлөөллөөс үл хамаарах, хүний үйл ажиллагаатай холбоотой доройтлыг ялган илрүүлэх боломжтой. Энэхүү дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Монгол орны газрын бүтээмж нь агаарын температуртай харьцуулахад хур тунадас нь илүү өндөр хамааралтай байсан бөгөөд энэхүү хандлага нь ялангуяа хагас хуурай бүс нутгуудад илүү тод илэрсэн. Эдгээр үр дүн нь RESTREND аргачлал бол хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтлыг уур амьсгалын суурь нөхцөлөөс нарийвчлалтайгаар ялган таних үр дүнтэй хэрэгсэл болохыг харуулж байна.

Дүгнэлт:

Олон эх сурвалжийн хиймэл дагуулын болон статистикийн цуврал өгөгдөл, хиймэл оюуны дэвшилтэт аргуудыг ашигласнаар Монгол орны газрын өөрчлөлт, доройтлын үйл явцыг орон зайн болон цаг хугацааны огтлолцолд нарийвчлалтай үнэлэх боломжтойг батлан харуулж байна. 1990–2019 он хүртэл 30 жилийн хугацаанд агаарын температур огцом өсөж, хур тунадас их хэлбэлзсэн нь хөрсний чийг ба органик бодисын алдралд нөлөөлж, салхи, усны элэгдлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Газар ашиглалт-газрын бүрхэвчийн өөрчлөлтийн шинжилгээгээр ой, хээр, хуурай хээр, тариалангийн талбай буурсан, элсжилт, ургамалгүй халцгай газар, хот суурины талбай нэмэгдсэн нь нүүрстөрөгч хадгалах чадамжийг сулруулж буй гэсэн үг юм. Түүнчлэн хур тунадас, температур, ургамлын индексийн 1990-2019 оны цуврал өгөгдөлд суурилсан хандлагын шинжилгээгээр Монгол орны баруун 5 аймгийн дийлэнх газар нутгийн хэмжээнд, мөн Дорноговь аймгийн өмнөд, баруун өмнөд

хэсгээр сөрөг хандлага илэрсэн байхад Дорноговь аймгийн хойд хэсэг болон Дундговь, Өмнөговь аймгийн дийлэнх нутгаар эерэг хандлага илэрсэн байна. BFAST алгоритмын шинжилгээгээр илрүүлсэн бүтцийн хугарлууд нь түймэр, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхай, хотжилт зэрэг тасалдлын голомтуудтай орон зайн хувьд тод илэрсэн байна. Гангийн индексийн шинжилгээгээр 1997, 2002, 2005–2007, 2017 онуудад хэт хуурай, гандуу жилүүд тохиолдсоныг илрүүлсэн. RESTREND аргаар хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй доройтлыг орон зайн хувьд тодорхой ялгаж харуулж чадсан. Эдгээр үр дүн нь нотолгоонд суурилсан газрын менежмент, бодлого төлөвлөлтөд шууд ашиглагдахуйц бөгөөд урт хугацааны цуврал өгөгдөл болон хиймэл оюуны дэвшилтэд аргуудыг ашиглах нь үндэсний түвшний мониторинг, эрсдэлийн үнэлгээнд үр ашигтай хэрэгсэл болохыг харуулж байна.

Түлхүүр үг: Газрын доройтол, тандан судалгааны өгөгдөл, машин сургалтын арга, хандлагын болон үлдэгдлийн шинжилгээ

ОЮУ ТОЛГОЙ - ГАШУУН СУХАЙТ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ДАГУУ ОРШИХ ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ

/Техник болон биологийн нөхөн сэргээлтийн жишээн дээр/

Д.Өлзийбаяр¹, Ш.Дэлгэрсайхан¹, Ц.Мядагмаа¹, Х.Билгүүн¹, Р.Мөнхбаяр¹,
Б.Буянжаргал¹, Бу.Түвшинжаргал¹, Ба.Түвшинжаргал¹, Б.Очирхуяг¹, Р.Нарангоо¹,
Б.Энхжаргал¹, С.Эрдэнэбат¹, Л.Мягмаржав², Б.Дашням², О.Цээсүрэн², А.Буд²,
Э.Алтанцэцэг²

¹ Нөхөн сэргээлтийн баг, Өлзий Энвэйронментал ХХК

² Байгаль орчны хэлтэс, Биологийн олон янз байдлын баг, Оюу Толгой ХХК

Хураангуй

Монгол Улсын “Газрын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх журам” зэрэг эрх зүйн баримт бичгүүд нь байгаль орчны доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажлыг эрх зүйн хүрээнд зохицуулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх суурь зарчмыг тодорхойлсон байдаг. Эдгээр хуульд заасны дагуу эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга технологийг хэрэгжүүлэх нь зөвхөн цөлжилтөөс сэргийлж, байгаль орчныг хамгаалахаас гадна эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү нөхөн сэргээлтийн ажлын зорилго нь эвдрэлд орсон газрыг анхны төлөв байдалд нь ойртуулах, бохирдлыг арилгах, хүн болон мал амьтны эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тухайн орчны экосистемийн нөхцөл байдал, газрын байгалийн унаган тогтоц, ургамалжилтын төрөл зүйл зэргийг харгалзан үзэж, байгаль орчны унаган төлөвийг сэргээхэд чиглэсэн техникийн болон биологийн арга хэмжээг цогцоор нь авч үзсэн юм.

2024 болон 2025 онд гүйцэтгэсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил нь 2012 онд баригдсан Оюу Толгой ордоос Гашуун Сухайт хүртэлх автозамын бүтээн байгуулалтын явцад түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга, дайрга олборлож ашигласны үр дүнд эвдрэлд орсон газруудад хэрэгжүүлсэн. Энэхүү эвдэрсэн газар нь экосистемийн хувьд маш эмзэг бөгөөд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй доройтол, цөлжилтийн асуудалтай тулгарч байгаа нь нөхөн сэргээлтийн ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт нь эдийн засгийн өндөр ач холбогдолтой хэдий ч байгалийн унаган тогтцыг алдагдуулах, орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох хөрс, ус, агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ

төрлийн орд газрууд нь их хэмжээний ухаш, хөндөгдсөн талбай үүсгэдэг бөгөөд нөхөн сэргээлтийн ажлын онцлог нь ухашийн өнцөг, хэвгийг хэлбэржүүлж, хөрсийг нөхөн сэргээх замаар гүйцэтгэдгээрээ бусад ашигт малтмал олборлосон талбайн нөхөн сэргээлтийн ажлаас ялгаатай.

Аргазүй:

Оюу Толгой - Гашуун Сухайтын автозам дагуу эвдэрсэн газруудад нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ тухайн орчны онцлогт тохирсон арга, технологийг ашиглан, ургамалжилтыг сэргээх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, экосистемийн тогтвортой байдлыг хангах зорилт тавьж үндсэн дөрвөн арга зүйгээр нөхөн сэргээлт хийсэн. Үүнд:

1. Хэлбэршүүлэх техникийн арга зүй

- *MNS5917:2008 “Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага”*
- *2015/03/30 А-138 “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”*
- *2022/08/29 А-328 “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”*
- *2010/05/17 А-132/112 “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал”*
- *ОТ-10Е14-PRC-0010-D “Нөхөн сэргээлтийн журам”*
- *ОТ-10Е14-PRC-0001 “Шимт болон шимэрхэг хөрстэй ажиллах журам”*

2. Усан үрлэгээ хийх арга зүй

- *MNS5918:2023 “Байгаль орчин. Эвдэрсэн гадрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага”*
- *MNS5995:2009 “Мод сөөгний үр. Үрийн чанарын албан баталгааны маягт”*
- *MNS2432:2009 “Мод сөөгний үр. Үрийн амьдрах чадварыг тодорхойлох стандарт”*

3. Хуурай үрлэгээ хийх арга зүй

- *MNS4969:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа”*
- *MNS2418:2011 “Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах стандарт”*
- *ОТ-10-Е14-PRC-0010-D “Оюу толгой ХХК-ны Нөхөн сэргээлтийн журам стандарт журам” зэрэг шаардлагуудыг хангаж сэндэчлэгээ, борнойдолт, хөрс элдэниүүлэлтийг хийж ажиллав.*

4. Тарьц, суулгац тарих арга зүй болно.

- *MNS6258-1:2011 “Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага”*

- *MNS6140:2010 “Мод сөөгийн тарь, Техникийн шаардлага”*
- *MNS6141:2010 “Навчит төрлийн модны суулгац, Техникийн шаардлага”*
- *MNS6141:2020 “Навчит модны суулгац, Техникийн шаардлага”*
- *MNS6255:2011 “Сөөгийн суулгац, Ерөнхий шаардлага”*
- *MNS6256:2011 “Сөөгөнцрийн суулгац, Ерөнхий шаардлага”*
- *MNS6773:2019 “Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах техникийн шаардлага”*
- *MNS6774:2019 “Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах”*
- *MNS6371:2013 “Жимсний модны тарьц суулгацыг түр хадгалах, тээвэрлэх”*
- *OT-10E14-PRC-0007 “Ховор ургамал хамгаалах журам”* зэрэг стандарт аргыг баримтлав.

Үр дүн:

Тус дөрвөн төрлийн арга зүйгээр 2024-2025 онд нийт 52 хэсэг, 122 га талбайд эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, тэг осолтой 25,300 хүн/цагийн хөдөлмөр зарцуулж нөхөн сэргээлт хийсэн юм. Эдгээр арга зүйн дагуу эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ургамалжилтыг сэргээхэд чухал ач холбогдолтой.

Хэлбэршүүлэх техникийн арга зүйгээр нийт 4 хэсэг талбайг хүн, мал, амьтны эрүүл мэндэд аюулгүй болгон хэлбэршүүлж, Монгол улсын холбогдох стандартын шаардлагад бүрэн нийцүүлэн налуулж, тогтворжуулсан юм.

Нийт 25 зүйлийн нутгийн унаган ургамлын 62,200 тарьц, суулгацыг бичил талбаруудын хөрсний болон экологийн онцлогийг ургамлын биологийн шинж чанартай уялдуулан хуваарилалт хийж, суулгац суулгах талбайг 30-40 см диаметртэй өрмөөр өрөмдөж бэлтгэсэн. Тогоо үүсгэсний дараа услах гадаргууг 50-60 см болгож, суулгацын өсөлт, хөгжлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэн.

Хуурай үрлэгээний технологийн арга зүйгээр нутгийн унаган ургамлын 13 зүйлийн үрийг хөрсөнд гүн суулгах, салхинд хийсэхээс сэргийлэх, хөрсөнд бэхжүүлэх нөхцөлийг хөрс боловсруулалт-үрлэлт-дахин хөрс боловсруулалт-цэнэг усалгаа гэсэн дарааллаар бүрдүүлсэн.

Нөхөн сэргээсэн шимт хөрс багатай, чулуурхаг хадтай хэсгүүдэд 60-80%-ийн барьцалдуулагч бодистой 13 зүйлийн нутгийн унаган ургамлын үрийг зуурмаг хэлбэрээр хольж, гадаргуу дээр 7-12 мм зузаантай бүрхүүл үүсгэн усан үрлэгээ хийв. Энэхүү усан үрлэгээний арга нь хөрсний гадаргуугаас чийг алдагдахаас сэргийлж, үрийг тогтвортой бэхжүүлж өгөхөд үр дүнтэй.

Дүгнэлт:

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд тухайн нөхцөлд нийцсэн нөхөн сэргээлтийн аргачлалыг хэрэгжүүлж, ургамлын төрөл

зүйлийн бүрдлийг сайжруулах арга хэмжээ авч ажилласан нь нөхөн сэргээлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой, үр дүнтэй арга хэмжээ болж байна.

Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд тусгайлсан аргачлал, технологийг ашиглан эвдэрсэн газрыг экосистемийн хувьд хүн, мал амьтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой байна. Энэ үйл ажиллагаа нь цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй ажил болсон юм.

Түлхүүр үг: Хуурай үрлэгээ, усан үрлэгээ, тарьц суулгац тарих, нутгийн унаган ургамал, хөрс боловсруулалт

ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХЭД УРГАМЛЫН БИОТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

Д.Өсөхжаргал¹*, Ө.Уянзул¹

¹ Шинжлэх Ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн

*Холбоо барих зохиогчийн цахим хаяг: usukhjargald@mas.ac.mn

Хураангуй

Монгол орны нийт газар нутгийн 76 орчим хувьд нь цөлжилт, газрын доройтлын нөлөө илрээд байгаа бөгөөд энэ үйл явцад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь уур амьсгалын өөрчлөлт юм. Судалгааны дүнгээр сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны дундаж агаарын температур 2.5°C-ээр нэмэгдсэнээр дэлхийн дундажтай харьцуулахад хоёр дахин өндөр байна. Ийм өөрчлөлт нь бүс нутгийн экосистемийн тогтвортой байдал, бэлчээрийн нөөцийн зохистой ашиглалт, хүн амын амьжиргааны баталгаанд ноцтой эрсдэл дагуулж байна. Энэ сорилтыг даван туулахын тулд хуурайшилт, усны хомсдол, хөрсний давсжилтад дасан зохицох чадвартай байгалийн ургамлын төрлүүдийг сонгон үржүүлэх замаар экосистемийн нөхөн сэргээх үйл явцад ашиглах түлхүүр зүйл болгон ашиглах шаардлага бий болж байна. Энэ үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй туршилт, судалгаа, арга зүйгээр баталгаажуулан шинэ мэдлэг, инновацлаг технологи боловсруулж нэвтрүүлэх нь цөлжилттэй тэмцэх үндсэн арга замын нэг юм.

Манай орны байгалийн 6 бүс бүслүүрт тархан ургадаг 160 гаруй зүйл мод, сөөг ургамал бүртгэгдсэнээс 30 гаруй зүйлийг нь үрээр тарих арга технологи, стандарт гарсан байдаг. Уламжлалт аргаар үр, суулгацаар ургамал үржүүлэх нь цаг хугацаа их шаарддаг, уур амьсгалын нөхцөлд ихээхэн хамааралтай, сортын хувийн онцлогийг хадгалах боломж хязгаарлагдмал байдгаас гадна үр, суулгацын олдоц, нөөц, гарц хомс байдаг зэрэг тухайн арга, технологиор үржүүлэх үйл явц, гарах тарьц суулгацын тоог хязгаарлах хүчин зүйлс болдог. Харин биотехнологийн аргаар *in vitro* нөхцөлд ургамлын эс, эдийг өсгөвөрлөж, богино хугацаанд их хэмжээний үрсэлгээ гаргах, стресс хүчин зүйлд тэсвэртэй сортыг сонгон үржүүлэх боломжтой болсон нь цөлжилттэй тэмцэхэд ашиглах өндөр үр дүнтэй ургамлын сортыг гаргаж авах боломжтой болсныг харуулж байна. Өнөөдрийн байдлаар “Оюуны өмчийн газар”-ын мэдээллийн санд 20 орчим зүйлийн модлог ургамлыг биотехнологийн аргыг ашиглан эс, эдийн өсгөврийн аргаар амжилттай гарган авсан туршилт судалгааны үр дүн бүртгэгдсэн байна. Бид сүүлийн 10 орчим жилийн хугацаанд экологи-эдийн засгийн өндөр ач холбогдолтой Орос махирс (*Lycium ruthenicum* Murr.)-ийг эсийн бөөгнөрөл буюу каллусын өсгөврөөр ургамал нахиа нөхөн төлжүүлэх замаар нэг үрээс

дунджаар 10 бодгаль нөхөн төлжүүлэх боломжтой тогтоосон бол манай орны ойн сангийн 10 гаруй хувийг эзэлдэг хусны төрлийн нэг зүйл Хавтаг навчит хус (*Betula platyphylla* Suzacev.)-г үе зайдмын эксплантаас нөхөн төлжүүлэх аргаар олшруулж, нэг үрээс дунджаар 15 бодгаль гарган авах боломжтойг тогтоосон.

Түлхүүр үг: Биотехнологи, *Betula platyphylla*, *Lycium ruthenicum*, нөхөн сэргээлт, ойжуулалт

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:

**ГАНДУУ БҮС НУТАГ,
БЭЛЧЭЭРИЙН ТОГТВОРТОЙ
МЕНЕЖМЕНТ БА ХУУЛЬ ЭРХ
ЗҮЙН ОРЧИН**

БЭЛЧЭЭРИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

П.Түмэнбаяр¹

¹ Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам

Хураангуй

Бэлчээр нь байгалийн баялаг бөгөөд газрын доорх баялгаас нөхөн сэргээгдэх боломжтой байдагт үнэлж баршгүй ач холбогдол оршино. Монгол орон газар нутаг өргөн уудам учраас бэлчээр хүрэлцээтэй юм шиг өнгөц бодох, нөхөн сэргээгдэх байдалд хэт найдах буруу ойлголт газар авчээ. Бэлчээр хүрэлцээтэй эсэхийг газар нутгийн хэмжээгээр бус тухайн орчинд байгаа мал, амьтны тэжээлийн хэрэгцээг хангаж байгаагаар тодорхойлдог.

Монгол Улсын бэлчээрийн газар нь нийт нутаг дэвсгэрийн 82.6 хувь буюу 129.3 сая га газар¹-ыг эзэлдэг бөгөөд үүнээс улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр 730.0 мян.га талбайтай юм. Улсын хэмжээгээр 2024 онд 57.6 сая толгой мал, 249.4 мянган малтай өрх, үүнээс 195.7 мянган малчин өрх² байна.

Мал аж ахуйн салбар нь бэлчээрийг ашиглан хүнсний хангамж аюулгүй байдал, эдийн засагт бодит хувь нэмэр оруулдаг. Тухайлбал хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нь 2025 оны I улирлын байдлаар ДНБ-ий хуримтлагдсан өртөг 35.6 хувиар өссөн байна.

Малын тоо сүүлийн жилүүдэд тодорхой хувиар өсөж 2022 онд 71.1 сая толгойд хүрсэн ба 2023 онд 6.3 сая, 2024 онд 7.2 сая толгойгоор тус тус буурсан хэдий ч бэлчээрийн даац, багтаамж хэтрүүлсэн хэвээр байгаа нь газрын доройтол, талхагдлыг улам нэмэгдүүлж улмаар малчдын амьжиргаа төдийгүй, улсын эдийн засагт ч сөргөөр нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайланд³ бэлчээрийн доройтлыг үнэлсэн дүнгээр нийт судалгааны талбайн 18% нь бага зэрэг, 22% нь дунд, 18% нь их доройтсон бол 11% нь хүчтэй доройтсон зэрэглэлд буюу чанараа алдсан судалгааны дүн гарсан байна.

Мөн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулагч мэрэгч амьтад малын идээшилдэг ургамал, өвсний хэмжээг бууруулж, улмаар тэжээлийн нөөцийг хомсдуулснаар малын тарга хүч авах боломжийг багасгах, зүй бус хорогдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөг мал аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлж байна. Бэлчээрийн гуравны нэг орчим хувь буюу 40 орчим сая га талбайд үлийн цагаан

¹ Газрын нэгдмэл сангийн 2024 оны улсын нэгдсэн тайлан

² ҮСХ-ний мэдээ, 2025

³ Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2021 он

⁴ Монгол оны цөлжилтийн атлас, 2020

оготно тархсан байгаа нь доройтолд өртсөнийг илтгэнэ. Тодруулбал, 2024 онд 12 аймгийн 100 гаруй сумын бэлчээрт мэрэгч амьтдын тархалт хэвийн байх хэмжээнээс хэтэрсэн бөгөөд энэ нь нийт бэлчээрийн 34.5 хувийг эзэлж байгаа юм. Жил жилийн цаг агаарын нөхцөл байдал, тухайн амьтны үржил зэргээс хамааран 5-10 сая га талбайд голомтлон тархсан байдаг. Энэхүү тархалт нь цаашид улам нэмэгдэж уулархаг нутагт тэлэх хандлагатай байгааг эрдэмтдийн судалгаагаар тогтоогдоод байна. Тархалтын хүрээ тэлж байгаа нь бэлчээрийн ургамлын ургац муудах, тачир сийрэг ургацтай болж үлийн цагаан оготно мэт мэрэгч амьтны амьдрах тохиромжтой орчин бүрдүүлснээр бэлчээрийн даац хэтэрч ачаалал улам бүр ихсэхэд нөлөөлж байна. Бэлчээрийн талхлагдвал, доройтол нь мал аж ахуйн салбарын чадавхыг бууруулах шууд хүчин зүйл болж, ган зуд, бусад эрсдэлд улам эмзэгших ноцтой сөрөг үр дагавар учруулж байна.

Монгол Улсын хэмжээнд нийт газар нутгийн 76.8 хувь цөлжилтөд өртсөн судалгаа байна⁴.

Бэлчээрийн ашиглалт, төлөв байдал нь уур амьсгал, тухайн жилийн цаг агаарын нөхцөл, малын тоо, малчдын нүүдлийн хэв маяг, салаа замаас шууд хамааралтай боловч бэлчээрийн тогтвортой менежментэд дараах зарим асуудал сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- Бэлчээрийн эрх зүйн зохицуулалт зарим талаар хангалтгүй байна. Нүүдлийн мал аж ахуйд бэлчээр ашиглалтын аргууд нь уламжлагдан ирсэн байдаг хэдий ч сүүлийн жилүүдэд дэд бүтэц, малчдын мал маллагааны арга, уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч алдагдаж байна. Мөн түүнчлэн бэлчээрийг нийтээр ашигладаг тул хамгаалах, зохистой ашиглахад тавих хяналт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ сул байгаа нь өнөөгийн бэлчээрийн даацын хэтрэл, доройтол, цөлжилт зэрэг тулгамдсан асуудлуудыг үүсгэж байна;
- Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалахад эдийн засгийн хөшүүрэг болох урамшууллын болон татвар бусад төлбөрийн тогтолцоо үйлчилдэггүй;
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор бэлчээрийн ургацын хэмжээ буурсан;
- Бэлчээрийн ашиглалт, хуваарилалтыг орон нутагт шийдвэрлэх удирдлага, зохицуулалт хангалтгүй;
- Малчид өөрийн малын тоог өсгөхийг эрмэлзэж бэлчээр, усыг өрсөж ашиглах сэтгэлгээтэй байгаа нь бэлчээрийн даацыг хэтрүүлж, мал аж ахуйн салбарт нэгдмэл удирдлага, зохион байгуулалт алдагдсан гэж үзэж болохоор байна.
- Тэжээлийн нөөц хомсдохын зэрэгцээ булаг шанд ширгэснээр бэлчээрийн усан хангамж багасаж байна.

Улсын эдийн засгийн гол тулгуур багана болсон мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд бэлчээрийн бүтээмж, экосистемийн төлөв байдал, малчин хүний мал маллагааны арга туршлага, бэлчээрийг шинжлэх ухааны

үндэстэй ашиглаж, хамгаалах асуудал чухал юм. Иймд цаашид дараах асуудлууд анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

- Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт тавих,
- Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, доройтлоос урьдчилан сэргийлэх шинжлэх ухааны үндэстэй зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх,
- Ган, зудын нөхцөлд ашиглах отрын нөөц бэлчээрийг тодорхойлох, улмаар ашиглалтын менежмент, тэжээл, усны нөөцийг хамгаалж, зохистой ашиглах, хамгаалах,
- Малчдын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, малчдын залгамж халаа, мал зүй, бэлчээр, тэжээлийн чиглэлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах,
- Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн оновчтой тогтоож, сүрэгт эзлэх эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулж сүргийн бүтэц, чанарыг сайжруулах замаар бэлчээрийн ачааллыг бууруулах, эдийн засгийн үр ашигтай байх, хариуцлагатай мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангах,
- Голын эх, булаг, худаг уст цэгийг хамгаалах, сайжруулах,
- Малчид хадлан сайжруулах, тэжээлийн ургамал тариалж малдаа тэжээл бэлтгэдэг боломж нөхцөлийг бүрдүүлж, тэжээлийн дутагдлыг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Түлхүүр үг: Бэлчээрийн ашиглалт, хамгаалал, бодлого

AN EVALUATION OF THE SOCIO-ECONOMIC EFFECTS OF DROUGHT CONDITIONS IN MONGOLIA DURING THE PAST 42 YEARS

Altantuya. D^{1,2,*}, Myagmartseren. P², Ganchodor. Ts¹

¹*Institute of Geography and Geoecology, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar 15170, Mongolia*

²*Department of Geography, National University of Mongolia, Ulaanbaatar 14201, Mongolia*

*Corresponding author: altantuyad@mas.ac.mn

Abstract

The recent conclusions from international research organizations, including the Intergovernmental Panel on Climate Change, related global warming to all aspects of human activities, especially the energy sector. Mongolia is one of the countries where the effects of climate change, especially warming occur faster than the global average. Over the past 80 years, the average air temperature in Mongolia has increased by 2.46°C, which has significantly affected ecosystem balance, national development, and people's lives. The major portion of the negative impacts of the global change in Mongolia is directly linked to the increased frequency and intensity of droughts, which is well pronounced in both environmental and socio-economic sectors.

Drought is one of the biggest challenges to Mongolia's environment and economy. Especially at the grassroots level. For a country whose people's livelihood mainly depends on a nomadic livestock breeding system, drought has become a significant threat diminishing local adaptive capacities to changing climate. Over the past 70 years, the intensity of droughts in Mongolia has tripled, and the continuous increase in the frequency of natural disasters demands urgent attention.

This study considers drought as a process that affects the environment and socio-economy spatiotemporal manner, depending on the geographical conditions and climate systems. This research aims to evaluate the impact of drought on Mongolia's society and economy and identify. To achieve this, the following objectives have been set:

1. Analyze changes, frequency, and intensity of drought using continuous temporal and spatial data to identify patterns.
2. Evaluate the multifaceted nature of drought impacts using modern statistical models based on big data related to climate, nature, society, and economy.
3. Assess the resilience to drought at the administrative level in Mongolia and evaluate its associated risks.

Within this research framework, big data encompassing geographic, climatic and

socio-economic factors were employed to analyze the conditions defining drought and the extent of its impacts. Spatial analysis was conducted using ERDAS Imagine, ArcMap, and ENVI software, while statistical analysis employed SPSS, EViews, and Microsoft Excel. For drought evaluation, we used remote sensing methods such as the Vegetation Health Index (VHI), with the Standardized Precipitation-Evapotranspiration Index (SPEI) employed to validate results based on meteorological data.

The findings were compared with other geographic baseline data to delineate the spatial risk zones of drought across Mongolia. Furthermore, the socio-economic losses due to drought were assessed using 30 indicators across livestock, agriculture, economic, and social dimensions, highlighting differences at both provincial and national levels. The temporal dynamics and intensity of drought exhibit significant fluctuations across the country. High-intensity drought years were observed in 1980, 2000, 2001, 2002, 2004, 2006, 2007, 2008, 2010, and 2017, while wet years were registered in 1983, 1984, 1985, 1987, 1989, 1990, 1991, 1993, 1994, 2003, 2013, and 2021. Drought phenomena in Mongolia are generally characterized by extreme heat and low precipitation. When average total precipitation during the warm season is estimated between 100-110 mm, the risk of drought is considered high. Additionally, when the average seasonal temperature exceeds 15 degrees Celsius, with more than three consecutive days with temperatures over +30 - +33 degrees, intense drought conditions are likely to occur.

Mapping the spatial distribution of drought reveals a trend of increasing intensity in central and northern Mongolia. Satellite data on soil moisture corroborates this, showing that the northern regions have experienced the greatest moisture loss over the past 42 years, aligning with the results of the field measurement. Notably, the most severe drought impacts occur when dry condition continues throughout the June, July, and August, consecutively. The data analysis revealed that from 2000 to 2010, the highest frequency of intense droughts occurred, with seven out of ten years registered as drought years. Conversely, the frequency of drought-free or relatively wet years was most pronounced between 1980 and 1990, during which five out of ten years were relatively wet.

Analyzing the trends in the SPEI index indicates that during transitional years between wet and dry decades, conditions tended to be slightly drought-like or marginally dry, with the longest duration of such conditions observed between 2005 and 2015.

Based on the results of the SPEI analysis, the assessment of drought's impact on Mongolia's socio-economy over the past 42 years reveals significant variation in losses and indicators across different provinces, influenced by geographical location and socio-economic factors. Specifically, in terms of the impact on livestock, indicators such as non-productive losses of large livestock, the number of insured animals, and the number of aborted livestock have shown strong effects, particularly

in provinces like Gobi-Altai, Bayankhongor, Uvurkhangai, Dundgovi, Govisumber, Khovd, Arkhangai, and Umnugovi.

In the agricultural sector, drought has notably affected total productivity of the agriculture sector, the area cultivated, and the amount of crop or hay harvested, with the strongest impacts observed in provinces like Bulgan, Khovsgol, Bayan-Ulgii, Uvs, Arkhangai, Bayankhongor, Uvurkhangai, Tuv, Selenge, Darkhan-Uul, Khentii, Dornod, Sukhbaatar, Bulgan, and Uvs. From an economic perspective, drought has influenced Gross Domestic Product (GDP), non-performing loan balances, and total savings, with significant fluctuations noted in Zavkhan, Arkhangai, Bulgan, Selenge, Tuv, Khentii, Dornod, Sukhbaatar, Khentii, Dornod, Uvurkhangai, Gobi-Altai, Bayankhongor, Govisumber, Dundgovi, and Dornogovi. Socially, drought has substantially impacted indicators such as population migration, livestock theft, the number of people migrating, divorce rate, and unemployment, as evidenced by the research findings.

The research findings indicate that, with respect to the scale of economic losses caused by drought, the provinces and soums located within the Gobi Desert and steppe zones have suffered the most severe impacts. This pattern highlights the vulnerability of these regions due to their specific climatic and geographical characteristics, which exacerbate the effects of prolonged drought conditions.

Keywords: Mongolia, drought, socio-economic impacts, climate change, livestock, agriculture

МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН ДОРОЙТОЛ БА ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД

Ж.Ундармаа¹

¹ ХААИС-ийн Агроэкологийн сургууль, Экосистемийн судалгааны төв

Хураангуй

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 66.4 хувийг эзэлдэг бэлчээрийн экосистем нь таван мянга гаруй жилийн турш нүүдлийн мал аж ахуйд суурилсан уламжлалт менежментийн тогтолцоогоор зохистой ашиглагдаж ирсэн. Гэвч сүүлийн арван жилийн хугацаанд уг экосистем хурдтай доройтож, экосистемийн үйлчилгээний чадамж алдагдах хандлага эрчимжиж байна. Бэлчээрийн доройтол нь зохисгүй ашиглалт, малын тооны хэт өсөлт, суурьшлын төвлөрөл, уламжлалт нүүдлийн хэв маягийн алдагдал, уул уурхайн олборлолтын тэлэлт болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг харилцан уялдаатай хүчин зүйлсийн нийлмэл нөлөөллөөр үүсэж буй цогц асуудал юм.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол орны нийт бэлчээрийн 22.4 орчим хувь нь ямар нэгэн түвшний доройтолд орсон бөгөөд тэдгээрийн дотор 15 орчим хувь нь байгалийн жамаар нөхөн сэргэх боломжгүй хэмжээнд хүрсэн байна. Энэхүү доройтол нь зөвхөн байгаль орчны асуудал төдийгүй, малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын зохицуулалт, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна.

Бэлчээрийн доройтлыг бууруулах, улмаар нөхөн сэргээхэд чиглэсэн үр дүнтэй шийдлүүд нь салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан, интеграцчилсан менежментийн хандлага шаарддаг. Үүний хүрээнд дараах үндсэн чиглэлүүдийг санал болгож байна:

1. Уламжлалт мэдлэгт суурилсан менежмент: Монголчуудын олон зууны турш ашиглаж ирсэн улирлын нүүдлийн зохистой тогтолцоо, нутгийн экологийн мэдлэгийг орчин үеийн менежментийн бодлогод тусган хэрэгжүүлэх.
2. Малыг тоог бэлчээрийн даацад нийцүүлэх: Малыг тооны өсөлтийг хязгаарлаж, малын үүлдэр, ашиг шимийг сайжруулах замаар бэлчээрийн экосистемд үзүүлэх ачааллыг бууруулах.
3. Нутгийн иргэдийн оролцоог хангах: Малчдын мэдлэг, оролцоонд суурилсан хамтын шийдвэр гаргалт, орон нутгийн бэлчээрийн менежментийг бэхжүүлэх.
4. Шинжлэх ухаанд суурилсан мониторингийн систем хөгжүүлэх: Бэлчээрийн төлөв байдлыг тогтмол хянах, үндэслэлтэй шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх орчин үеийн мониторинг, мэдээллийн сангийн

тогтолцоог бий болгох.

5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх:
Ган, зуд зэрэг цаг уурын гамшгийн эрсдэлийг бууруулах, тэсвэртэй менежментийн арга зүйг нутагшуулах.

Иймд уламжлалт болон орчин үеийн шинжлэх ухаанд суурилсан мэдлэг, туршлагыг уялдуулсан, нутгийн онцлогт тохирсон, шаталсан түвшний уялдаа бүхий бодлогын шинэчлэл, менежментийн интеграцчилсан тогтолцоо нь Монгол Улсын бэлчээрийн тогтвортой ашиглалт, нөхөн сэргээлтийн үндсэн гарц болох нь зүйтэй.

Түлхүүр үг: Бэлчээрийн доройтол, нүүдлийн мал аж ахуй, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой менежмент, нөхөн сэргээлт

LONG-TERM EFFECTS OF GRAZING MANAGEMENT AND NITROGEN ADDITION ON PLANT DIVERSITY AND ECOSYSTEM STABILITY IN THE MONGOLIAN DESERT STEPPE

Lyankhua Bayasgalankhuu^{1*}, Khatansaikhan Purevdorj¹, Enkhriimaa Narmandakh¹, Batzorig Tugsbayar¹, Tuvshintogtokh Indree¹, Nyambayar Nyamjantsan¹, Batzaya Gachmaa^{1,2}, Enkhmaa Erdenebileg¹, Sukhbat Altangerel¹, Davaagerel Munkhtur¹, Khulan Nyamsanjaa¹

¹ Botanic Garden and Research Institute, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar 13330, Mongolia

² University of Mongolian Academy of Science, Ulaanbaatar 13330, Mongolia

*Corresponding author: Lyalya2020@gmail.com

Abstract

Land degradation poses a major threat to the sustainability of grassland ecosystems worldwide, primarily driven by grazing pressure, climate variability, and altered nutrient dynamics. This study investigates the long-term effects (2010–2023) of grazing management (grazed versus ungrazed), nitrogen (N) addition treatments, and climatic and soil factors on vegetation structure, biodiversity, and ecosystem stability in a desert steppe ecosystem of Dalanjargalan, Mongolia. Our findings indicate that increased grazing pressure, particularly from goats, sheep, cattle, and camels, led to a marked decline in plant species richness and Shannon diversity. At the same time, grazing pressure enhanced community evenness by favouring the dominance of grazing-tolerant species. In contrast, grazing exclusion promoted vegetation recovery, thereby strengthening community stability and resilience. Moderate nitrogen addition positively influenced vegetation cover and species richness, while high nitrogen input reduced species diversity and evenness, indicating a threshold beyond which nutrient supplementation may become detrimental. Climatic variables, notably precipitation and wind speed, strongly influenced biodiversity patterns, emphasizing vulnerability to climate change-induced drought stress. Additionally, soil moisture and nutrient availability (carbon, nitrogen, potassium) significantly supported vegetation diversity, highlighting soil health as fundamental for ecosystem resilience. The findings highlight the critical need for integrated and adaptive land management strategies. These should encompass sustainable grazing practices, carefully regulated nutrient inputs, and explicit consideration of both climatic and edaphic factors. Such an approach is essential to effectively mitigate land degradation and foster ecosystem restoration in arid grasslands.

Keywords: Desert steppe, grazing exclusion, nitrogen addition, biodiversity, climate change, land degradation, Mongolia

ТАВДУГААР ХЭСЭГ:

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
ДАСАН ЗОХИЦОХ ШИЙДЛҮҮД**

ГОВИЙН БҮС НУТГИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ХАНДЛАГА БА ЭМЗЭГ БАЙДАЛ

Д.Дуламсүрэн¹, П.Гомболүүдэв¹, Г.Болоржаргал¹, Ц.Бат-Оюун¹

¹ Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн

Хураангуй

Монгол орны говийн бүс нутаг нь хуурай, нэн хуурай уур амьсгалтай (Б.Жамбаажамц, 1989) бөгөөд нар, салхины эрчим хүчний арвин нөөцтэй. Салхины жилийн дундаж хурд 3.5–5.0 м/с, хаврын улиралд 4.5–6.0 м/с болж нэмэгддэг. Жилд дунджаар 15–30 өдөр хүчтэй салхи (15 м/с-ээс их), 30–50 өдөр шороон шуурга тохиолддог.


Тус бүс нутгийн жилийн агаарын дундаж температур 1941–2024 оны хооронд 2.55°C-аар нэмэгдсэн бөгөөд хамгийн эрчимтэй дулааралт хаврын улиралд илрэх болсон. Ялангуяа хуурайшлын үе эхлэхтэй давхцан хаврын улиралд агаарын температур 3.2°C-аар нэмэгдэж байгаа нь экосистем, усны нөөц, мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж буй онцгой анхаарал татах үзүүлэлт юм. Жилийн нийлбэр хур тунадас ерөнхий хандлагаар 22.95%-иар өсөж байгаа боловч хур борооны төрөл зүйл өөрчлөгдөн аадар бороотой өдрийн тоо хоёр дахин нэмэгдсэн. Богино хугацаанд эрчимтэй орох хур тунадасны давтагдал нэмэгдсэн нь уруйн үерийн эрсдэлийг нэмэгдүүлж, газрын доройтлыг улам эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал: сүүлийн арван жилийн хугацаанд говийн бүс нутагт байгаль, цаг уурын гаралтай нийт 1212 гамшгийн тохиолдол бүртгэгдсэнээс 41.3 хувийг аадар борооны улмаас үүссэн үер эзэлсэн нь бүс нутгийн эмзэг байдлыг тод харуулж байна.

Мөн нутгийн 50 гаруй хувь нь хүчтэй болон нэн хүчтэй цөлжилтөд өртсөн (УЦУОСМХ, 2020) нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг даах чадвар сул, экосистемийн тэнцвэрт байдал алдагдах өндөр эрсдэлтэйг илтгэнэ.

Ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтийн тооцоогоор өнөөгийн нөхцөл байдал улам бүр эрчимжих төлөвтэй байна. Жишээлбэл, хамгийн эрсдэлтэй SSP5-8.5 сценарийн тооцоогоор өнөө үетэй харьцуулахад 2030 онд улирлын дундаж агаарын температур 1.1–1.4°C-аар, хур тунадас 4.5–18.6%-иар, 2050 онд 2.3–2.8°C-аар, хур тунадас 10–28.2%-иар тус тус нэмэгдэх төлөвтэй гарсан. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн судалгаанд хамгийн өргөн ашиглагддаг агаарын температурын захын утгад хийсэн тооцоогоор (зураг 1) хоногийн үнэмлэхүй их ба бага температурын тархалт хоёр оройтой байгаа нь өвөл, зуны улирлын ялгааг илтгэнэ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр энэхүү тархалт дулаан тал руу шилжиж буй нь тодорхой харагдаж байна. Жишээлбэл, агаарын үнэмлэхүй бага температурын эхний орой 1986–2005 онд -20°C орчимд төвлөрч

байсан бол 2030 онд -18°C , 2050 онд -15°C , 2100 онд -10°C орчимд шилжих төлөвтэй. Энэ нь хахир хүйтэн нөхцөл суларч, харин халуун, бүгчим өдрүүд давамгайлах чиг хандлагатай харуулж байна.

2D Graph 2



Зураг 1. Говийн бүс нутгийн агаарын температурын хоногийн хамгийн бага болон их утгын тархалт ба ирээдүйн хандлага (Obs, 2030, 2050, 2100 онууд)

Хур тунадасны хувьд нэг хоногт орох хамгийн их хур тунадас ($RX1day$)-ны хэмжээ 2030, 2050 онуудад өсөхөөр байгаа нь конвекцийн гаралтай хүчтэй аадар бороо нэмэгдэж, үерийн аюул ойр ойрхон тохиолдох төлөвтэйг итгэж байна. Үүнтэй зэрэгцэн агаарын температурын захын утга дулаан тал руу шилжиж, хэт халалтын давтамж нэмэгдсэнээр дэвсгэр гадаргын хуурайшилт эрчимжиж, онцгой хуурай жилүүдийн давтагдал мөн нэмэгдэх магадлал өндөр гарсан. Иймд уур амьсгалын ирээдүйн өөрчлөлтийн эрсдэлийг олон түвшинд үнэлж, гамшгийн эрсдэлийн менежмент болон дасан зохицох бодлогыг эрчимжүүлэх шаардлага шаардлага улам бүр тулгарч байна.

Түлхүүр үг: Говийн бүс нутаг, уур амьсгалын өөрчлөлт, хэт дулаарал, хур тунадасны өөрчлөлт, аадар бороо, үер, цөлжилт

OBSERVATIONS OF SAND AND DUST EMISSIONS AT TSOGT-OVOO IN THE NORTHERN PART OF GOBI DESERT, MONGOLIA SINCE 2012

Masahide Ishizuka^{1,*}, Yasunori Kurosaki² and Batdelger Gantsetseg³

¹ Faculty of Engineering and Design, Kagawa University, Japan

² Arid Land Research Center, Tottori University, Japan

³ Information and Research Institute of Meteorology, Hydrology, and Environment (IRIMHE), Mongolia

*Corresponding author: ishizuka.masahide@kagawa-u.ac.jp

Abstract

Asian Dust (Kosa) is a natural phenomenon in which strong winds emit soil particles from the dry ground surface into the atmosphere, causing long-distance transport on a global scale, from East Asia to Japan and beyond. It has a significant impact on the climate, including global warming and nutrient supply to the oceans. Asian dust also causes deterioration of the atmospheric environment. Furthermore, there are concerns that Asian dust and PM_{2.5} may affect the health of human and livestock. Therefore, an accurate estimation of the amounts of emitted sand and dust is important for accurately understanding not only local environmental changes, but also global environmental changes.

Long-term observations for the saltation sand and floating dust have been conducted at Tsogt-Ovoo in the northern Gobi Desert since 2012. Various ground surface observations are also being conducted.

The observations of sand and dust have revealed that complex changes in the ground surface affect on the occurrence of Asian dust. For example, studies have shown that soil crusts destruction may affect the occurrence of dust (Ishizuka et al., 2012), that land surface conditions such as soil moisture and freeze-thaw cycles affect threshold wind speed (Abulaiti et al., 2014), that topographic depression (valley) affect seasonal changes in vegetation amount (Gantsetseg et al., 2017), that the amount of gravel affects the threshold wind speed for sand saltation and dust (Buyantogtokh et al., 2021, 2022; Sekiyama et al., 2023), that the relationship between ground surface roughness and the threshold wind speed for sand saltation using estimates of dead grass amount based on MODIS satellite data (Wu et al., 2021), that seasonal changes in the threshold wind speed for sand saltation due to seasonal changes in ground temperature and vegetation using the DYCENT vegetation model (Kong et al., 2021), and that the land surface disturbance by livestock affects dust generation (Munkhtsetseg et al., 2017).

It is expected that these steady observations will contribute to improving the

accuracy of dust (KOSA) forecasts in Mongolia, Japan, East Asia, and around the world by the results of our research are applied to verifying the accuracy of numerical models of Asian dust. Another important concern is elucidating the impact of climate change, such as global warming, on Asian dust generation and its impact on human health. Furthermore, Asian dust observation site at Tsogt-Ovoo, jointly managed by Tottori University and IRIMHE, will give the advantage of being able to obtain highly accurate fundamental meteorological and hydrological data with sand/dust data.

Keywords: Asian dust, KOSA, Gobi Desert, desert steppe, saltation, dust emission, observation, ground surface conditions

ОРОН НУТГИЙН БОЛОН БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНИЙ ТООС ДЭГДЭЛТИЙГ ХИМАВАРИ-8/9 ГЕОСТАЦИОНАР ХИЙМЭЛ ДАГУУЛААР ИЛРҮҮЛЭХ

Б.Чүлтэм¹, Ч.Сономдагва¹, Юмимото Кэйя², Мацүки Ацүши³

¹Монгол улс, Монгол Улсын Их Сургууль, Инженер Технологийн сургууль

²Япон улс, Кюүшү Их Сургууль, Хэрэглээний Механикийн Судалгааны Хүрээлэн

³Япон улс, Каназава Их Сургууль, Байгалийн Шинжлэх Ухаан, Хүрээлэн буй Орчны Технологийн Хүрээлэн

Оршил

Уур амьсгалын өөрчлөлттэй хамт хүчтэй салхи шуурганы давтамж ихсэж, үүнийг дагасан тоосны дэгдэлтийн асуудал улам бүр анхаарал татах асуудал болж байгаа билээ. Уур амьсгалын горимоор Монгол улсын нутаг дэвсгэрт хавар, намрын улиралд агаарын массын шилжилтийн улмаас говь цөл, хуурай хээрийн бүсийн газрын гадаргаас тоос дэгдэх нь түгээмэл байдаг. Энэ нь эн тэргүүнд хүн амын эрүүл мэнд, цаашлаад эдийн засагт сөргөөр нөлөөлж бүс нутгийн хэмжээнд, тухайлбал БНХАУ, БНСУ, Япон зэрэг зүүн Азийн улс орнуудад хүрээлэн буй орчны томоохон асуудал болдог.

Монгол орны говь цөлийн бүс нь дэлхийн агаар мандлын тоос дэгдэлтийн гол цэгүүдийг нэг юм. Гэвч, сүүлийн жилүүдэд байгалийн бусад бүс бүслүүрээс тоос дэгдэх үзэгдэл ч ажиглагдах болсон. Хэдийгээр манай орны нутаг дэвсгэр тоосны дэгдэлтийн гол бүс нутаг боловч агаарын чанарын суурин хяналтын сүлжээ хангалтгүй түвшинд байна. Энэ асуудлыг шийдэж болох нэг арга зам нь хиймэл дагууллын мэдээллийг ашиглах явдал байдаг. Хиймэл дагуулын байрлах өндрийн төрлүүд дотроос геостационар (~35,8 мянган км өндөрт) буюу дэлхийн эргэлттэй дагах, цаг хугацааны өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулууд агаарын мандалд хурдан өөрчлөгдөх юмс үзэгдлийг хянахад цаг хугацаа, зардлын хувьд үр дүнтэй.

Байгалийн тоосны дэгдэлтээс гадна хүний үйл ажиллагаатай холбоотойгоор цэгэн эх үүсвэрээс тоос дэгдэж болно. Жишээлбэл, уурхайн бүс, тариалангийн талбай нь хөрсөн орчныг элэгдэл эвдрэлд оруулж салхины нөлөөнд хялбар өртөх байдалд хүргэдэг. Тоосны орон зай, цаг хугацааны тархалтыг тодорхойлсноор цаашид нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд ач холбогдолтой.

Бид энэхүү судалгаагаар, 1) Монгол орны томоохон уурхайн нэг болох Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын сангаас эх үүсвэртэй цагаан тоосны орон зай, цаг хугацааны тархалт; 2) Монгол орны нутаг дэвсгэрт тохиосон бүс нутгийн хэмжээний шороон шуурга, мөн тоосны цэгэн эх үүсвэрийг жил бүрийн 3–5-р сарын хугацаанд тодорхойлсон үр дүн; 3) цаашид хийгдэж буй ажлын талаар

танилцуулах болно.

Арга зүй

Химавари-8/9, Advanced Himawari Imager (АНИ).

Химавари–8 цаг уурын геостационар хиймэл дагуулыг 2014 оны 7 сарын 7-ны өдөр Японы цаг уурын агентлаг хөөргөсөн бөгөөд 2015 оны 7-р сарын 7-ны өдрөөс үйл ажиллагаанд орсон. 2022 онд Химавари–8 нөөцөд шилжиж 9 нь шинэчилсэн горимоор үндсэн үүргийг гүйцэтгэж байгаа.

Химавари–8/9 экваторт, зүүн уртрагийн 140.7 градуст байрлаж дэлхийн бөмбөрцгийн 1/3-ийг тогтмол хянаж байдаг. Хиймэл дагуулд суурилуулагдсан АНИ-ийн цаг хугацааны нарийвчлал нь 10-минут байдаг бөгөөд тасралтгүй мониторинг хийхэд хангалттай үр дүнтэй гэж тооцогддог. Орон зайн нарийвчлалын хувьд ~2 км. Спектрийн 0.47-13.3 мкм долгионы урттай 16 сувгаас бүрдэх бөгөөд хэт улаан туяаны сувгууд газрын гадарга, агаар мандал дахь бодисын найрлагаас ялгарах долгионы шинж чанарт тулгуурлаж хэмжилт хийдэг учраас нь өдөр, шөнийн алинд ч тоосны дэгдэлтийг хянах боломжийг өгнө.

Тоосны илрүүлэлтийг 8.6, 10.4, 12.4 мкм долгионы урттай сувгуудаар Dust RGB алгоритмаар зургийг гарган авч, түүнээсээ агаар мандлын тоосыг илэрхийлэх утгуудын тусламжтайгаар тархалтын зураг гаргах, тоосны дэгдэлтийн цэгэн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг гүйцэтгэсэн.

Суурин хэмжилт.

Хиймэл дагуулын мэдээг судалгаанд ашигласнаар цаг хугацаа, төсвийг хэмнэх боловч үр дүнгийн баталгаажуулалт хийгдэх шаардлагатай. Бид судалгаандаа Optical Particle Counter (PS2, Shinyei Technology Co.Ltd) болон Palm-sized PM2.5 гэсэн 2 төрлийн мэдрэгчийг ашигласан. Уг хямд-өртөгт мэдрэгчүүд нь тоосны хэсгүүдийг тархсан гэрлийн эрчим суурилан тодорхойлдог. PS2 нь 15 мкм-ээс дээш хэмжээтэй бүдүүн ширхэгт тоосонцрын тоон агууламжийг тодорхойлдог бол Панасоник Корпораци болон Нагоя Их сургуулийн зохион бүтээсэн Palm-sized PM2.5 мэдрэгч нь <2.5 мкм-ээс бага диаметртэй хэсгүүдийн масс агууламжийг гаргана. Эдгээр мэдрэгчийг хамтад нь ашигласнаар нарийн болон бүдүүн ширхэглэгт хэсгүүдийн бодит хугацааны хэмжилтийн мэдээг гарган авч чадна.

Үр дүн

Эрдэнэтийн цагаан тоосны тархалт.

Эрдэнэтийн цагаан тоосны орон зай, цаг хугацааны тархалтыг 10 минутын интервалтай хиймэл дагуулын мэдээлэл ашиглан тодорхойлсон. Үр дүнгээр, цагаан тоос нь хаягдлын сангаас 120 гаруй км зайд тархаж, тоосны тархалтын үед өртөлтийн талбай 2,400-2,750 км² хүрэх тохиолдол байсан. Мөн, Химивари

хиймэл дагуулын мэдээ нь хамгийн багадаа 312 км² талбайг хамарч, 40 км зайд тархсан тоосыг илрүүлж чадсан.

Монгол орны зонхилох салхины чиглэл болох баруун, баруун хойд зүгийн салхиар цагаан тоос нь тархаж байсан бөгөөд судалгааны хэмжилтийн багажийг Эрдэнэт хотын төв, мөн цагаан тоосны салхин доод талд суурилуулан тасралтгүй хэмжилт хийсэн. Хэмжилтийн үр дүн нь цагаан тоос дэгдэлт тохиосон үеүдийг тодорхой харуулсан. Тухайлбал, цагаан тоосны хаягдлын сангаас баруун зүгт орших хот доторх цэгт тоосны агууламж хэвийн байхад цагаан тоосны салхин доор орших цэгт тоосны агууламж маш өндөр байв. Энэ нь цагаан тоос зурвас байдлаар салхины чиглэлийн дагуу зөөгддөг гэдгийг харуулсан. Гэвч салхины чиглэлийн дагуу тариалангийн талбай, бэлчээр, усан орчин бий. Өмнөх судалгааны ажлаас үзэхэд, цагаан тоос нь зэс, молебдин зэрэг хүнд металлыг ихээр агуулсан байдаг. Мөн, хаягдлын сангийн тоосны нийт массын 95 хувь орчим нь 2-250 мкм буюу маш нарийн ширхэглэгтэй байжээ. Уг шинж чанарууд нь нөлөөллийн бүсэд оршин суудаг хүн амын эрүүл мэнд, амьдрах орчинд бохирдлын хуримтлал үүсгэж цаашлаад олон сөрөг үр дагавар бий болоход хүргэнэ.

Бүс нутгийн хэмжээний шороон шуурга ба тоосны цэгэн эх үүсвэр.

2017–2023 оны 3-5-р сард тохиосон шороон шуурга, тоосны тархалтыг зураглаж үр дүнг гарган авсан. 2017–2018 онуудад тоосны тархалт Монгол орны хэмжээнд харьцангуй бага байсан. Энэ хугацаанд, 10–31 өдөр тоосны дэгдэлт илэрч, бүс нутгийн хэмжээний шороон шуурганы 2–5 удаагийн тохиолдол бүртгэгдсэн. Тоосны цэгэн эх үүсвэр 25–59 байршилд илэрсэн.

2021 оны хувьд шороон шуурганы давтамж хамгийн өндөр байсан буюу 54 өдөрт нь тоос дэгдэж, 160 цэгэн эх үүсвэр тогтоогдсон. Мөн, 2021, 2023 онуудад тус бүр 17 удаагийн бүс нутгийн хэмжээний хүчтэй шороон шуурга тохиожээ. 2019, 2020, 2022 онуудад 4, 8, 6 удаагийн хүчтэй шороон шуурга бүртгэгдсэн. Жил бүрийн 4-р сард шороон шуурга хамгийн их тохиодог байна.

Тоосны дэгдэлтэд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлс бий. Тухайлбал, салхины хурд, цасан бүрхэвч, гадаргын биомассын бүрхэвч гэх мэт. Бидний ажиглалтаар тоосны дэгдэлт өндөр байсан жилүүдэд цасан бүрхэвч харьцангуй бага байв. Уур амьсгалын өөрчлөлттэй хамт хур тунадасны горимд өөрчлөлт гарч байгаа нь гамшигт үзэгдлийг нэмэгдүүлж байна. Мөн хүний нөлөөллийн улмаас газрын бүрхэвчид өөрчлөлт орж шороон шуурганы эрчмийг нэмэгдүүлж буй байдал мэдрэгдэж байна.

Дүгнэлт

Бид Химавари–8/9 геостационар хиймэл дагуулын цаг хугацааны өндөр нарийвчлалтай мэдээг ашиглан уурхайн хаягдлын сангийн цэгэн эх үүсвэрээс ялгарсан эх үүсвэр нь антропоген тоосны тархалтыг илрүүлэх анхны оролдлогыг

хийж, мөн Монгол орчны хэмжээнд хаврын улиралд тоосны тархалтын мэдээллийн сан үүсгэхийг зорилоо.

АНИ-ийн 10-минутын давтамжтай тоосны RGB зураг нь цагаан тоосны тархалтын үргэлжлэх хугацаан дахь өөрчлөлтийг тодорхой харуулсан. Эрдэнэтийн уурхай нь цаашид 60 орчим жил үйл ажиллагаа явуулах төлөвтэй байгаа бөгөөд цагаан тоосны дэгдэлтийн асуудал нөлөөллийн бүсэд оршин суух ард иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлсөөр байх тул энэ төрлийн судалгаа асуудлыг танин мэдэх, цаашлаад урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд өндөр ач холбогдолтой юм. Ажиглалт явуулах хэмжилтийн цэгүүд, дэд бүтэц хангалтгүй байдаг нь тоосны тархалтыг хянахад хүндрэл учруулдаг. Иймээс, орон нутгийн газар ашиглалтын өөрчлөлт, түүнтэй холбоотой тоосны антропоген эх үүсвэрүүд нэмэгдэж байгаа учир тоосны тархалтыг хянах, сөрөг нөлөөллийн бүсийг тогтооход Монгол орны өргөн удам газар нутагт геостационар хиймэл дагуулын мэдээг ашиглах нь мониторингийн ажлыг үр дүнтэй болгохоор байна.

Цаашид хийх зүйлс.

Байгаль цаг уурын өөрчлөлт нь дан ганц тухайн орны асуудал биш бөгөөд бүс нутаг, дэлхий нийтийн хэмжээнд яригдана. Япон болон Солонгос улсын судлаачидтай хамтран судалгааны үр дүнгийн хамрах хугацааг өргөжүүлж, агаар мандлын тоос илрүүлэлтийг сайжруулах алгоритмыг хөгжүүлж байна. Үр дүн хэсэгт дурдагдсан тоосны дэгдэлтэд нөлөөлөгч байгалийн хүчин зүйлийн мэдээг авч үр дүнгийн тайлбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийн тодорхойлогдох ажлын арга зүйг боловсруулах ажил мөн хүлээгдэж байна.

Түлхүүр үгс: Тоосны мониторинг; Химавари-8/9; геостационар хиймэл дагуул; цагаан тоос; тоосны эх үүсвэр

THE GOOD GROWTH MODEL: A PIONEER IN DEVELOPING VALUE SYSTEMS FOR LONG TERM REGENERATION

Cédric Bussac¹

¹ *Good Growth Communities*

Summary

The Good Growth model presents an innovative, holistic framework for sustainable rangeland regeneration in Mongolia. By combining ecological science, community engagement, and innovative economic agreements, it fosters nature-friendly supply systems that support herders, landscapes, and global supply networks. Its landscape-based and multi-product approach aligns economic incentives with ecological realities, enabling long-term recovery of Mongolian grasslands amid climate variability and socioeconomic challenges.

The Good Growth model for long-term rangeland regeneration in Mongolia is a nature-friendly, community-driven approach designed to address the rapid degradation of Mongolian grasslands. It builds supply coalitions that create favourable conditions for herding communities to implement adaptive management practices, particularly in response to highly variable abiotic factors such as climate change and overgrazing.

Background: The Problem of Rangeland Degradation in Mongolia

Mongolian rangelands occupy roughly 70% of the country's territory, representing one of the last remaining natural steppe ecosystems worldwide. These arid and semi-arid rangelands condition are mostly driven by stochastic abiotic factors and are in their vast majority publicly owned grazed by individual herders (households) who can cooperate or compete for pastures.

These grasslands are degrading rapidly, primarily due to two main factors: climate change and overgrazing. Over the past three decades, the livestock population in Mongolia has tripled and frequently exceeds the carrying capacity of the rangelands, resulting in serious ecological consequences. These include a loss of plant biodiversity, increased invasive species, and decreased pasture productivity. The combined pressures accelerate soil degradation and reduce the land's ability to store carbon, negatively impacting Mongolia's contribution to climate mitigation efforts.

Both herders and scientists observe that climate change is aggravating these problems. In particular, there is an increased frequency of extreme weather events such as droughts, heavy rains, and heavy snowfalls. These events disrupt growing seasons and lead to poor pasture yields, demanding specific adaptive management solutions. However, herding communities often maintain livestock numbers beyond

sustainable limits, mainly due to economic pressures. Although most herders have a deep respect for Nature, they are not stewards as they necessarily lead livestock centric, not landscape centric lives.

Today, there is no economic incentive for looking after nature. High livestock numbers are the results of value chains that are extractive by design: they are driven by multiple single buyers disconnected from the landscape which introduces a lack of resilience and economic fragility. One of the key economic drivers is cashmere, which accounts for nearly 90% of herders' income in the South Gobi. The cashmere supply system has been optimized for selling but not for nature. While volumes have been raising and both fibres and pastures quality are degrading, cashmere prices have been highly volatile and have barely increased in real terms over the last 20 years, while the cost of living has risen significantly. This economic imbalance incentivizes herders to keep livestock numbers high despite ecological consequences. We need economic incentives for looking after nature instead of extracting from it.

The Good Growth Model: An Innovative, Landscape-Based Approach

The Good Growth model offers a transformative approach that shifts the economic focus from maximizing commodity volume to respecting the ecological needs of landscapes. It does so by building “nature-friendly supply coalitions” and creating economic incentives aligned with ecological sustainability.

At the core of this approach is a precise identification of landscapes, herding communities living on these landscapes, and their resource use patterns. The model employs a participatory, community-based monitoring system grounded in the Mongolian Ecological Site Groups classification and its associated State and Transition Model. This system uses the “Recovery Class” metric adopted by Mongolian public agencies (ALAMGAC) to monitor ecosystem health and rangeland condition.

The monitoring approach increases the number of data points for assessing carrying capacity and dynamically adjusts their locations in collaboration with communities. This generates valuable, localized data, enabling communities to collectively manage livestock numbers based on ecological realities over long time horizons. A critical management tool enabled by the Good Growth model is the facilitation of seasonal mobility (otor) and collective grazing plans.

Economic Instruments for Sustainable Grazing

To create economic conditions that encourage communities to respect agreed stocking plans, including species composition rebalancing or necessary destocking, the Good Growth model incorporates two main features:

1. It accounts for all products generated from a landscape or community, not just one commodity.
2. It establishes long-term price agreements with communities that compensate

for production losses when destocking is necessary.

These elements form the backbone of the “Landscape Compact”: a long-term commercial agreement that links livestock numbers per species to production volumes and future prices. Currently focused on fiber production such as cashmere, the model is expanding to incorporate meat and dairy products.

This framework ensures that herding communities are financially supported while managing livestock sustainably, breaking the cycle of economic pressure leading to overgrazing. Additionally, the model supports herders by providing tailored “Nature intelligence,” including rangeland condition data, carrying capacities, and weather alerts, alongside organizing seasonal management meetings to coordinate community decisions effectively.

Connecting Landscapes to Markets: Building Clubs of Buyers

The Good Growth model seeks to address the demand side of the system where fashion brands are currently disconnected from the origin of their products and thus unable to have any individual influence. We are linking landscapes directly with fashion brands that want to have a positive impact on natural landscapes by providing them with intelligence on key leverage points where the market meets the landscape and drives productions and thus livestock numbers and their quality. We are currently piloting this approach with domestic and international partners, helping them to redesign their supply chains and testing with them different products issued from partnering communities.

Each Mongolian landscape has distinct capacities in terms of the type and volume of products it can sustainably produce. Rather than focusing on a single commodity like cashmere, **landscapes benefit from multiple value streams**. For example, fibers vary by species—camel wool in deserts, yak wool in mountains, horsehair for specialized tailoring, and sheep wool waste repurposed into fertilizers. Such diversity stabilizes landscape economies and enhances ecological resilience.

The model facilitates “clubs of buyers” where multiple brands commit to purchasing a range of fiber qualities and types originating from a single landscape. This arrangement secures long-term market access while supporting the landscapes’ ecological limits and regenerative potentials.

Currently, Good Growth works in partnership with numerous international brands adapting to evolving regulations, such as those in the European Union, helping them secure volatile supply chains while transitioning from extractive to regenerative business models.

Scientific Foundation and Rangeland Recovery Potential

The Good Growth model is supported by robust science and monitoring frameworks developed through national and international collaborations. Mongolian

scientists, government agencies, and non-profits have created standardized methodologies for assessing rangeland health, including Ecological Site Descriptions and State and Transition Models.

Mongolia's national reports reveal that although 65% of rangelands are degraded, approximately 94% retain recovery potential if managed carefully. Even heavily degraded areas can recover with more than ten years of sustained, adaptive management strategies focused on resting rangelands during critical growth periods and adjusting grazing intensity seasonally.

Resilience-based rangeland management integrates traditional practices, such as rotational grazing and pasture resting, with modern monitoring technologies and legal frameworks. This integrative approach promotes sustainable livestock production while protecting ecosystem functions critical for climate mitigation, animal health, and community livelihoods.

Key words: Rangeland condition, Mongolia, herding sector, regenerative agriculture, adaptive grazing, landscape, value systems, regenerative economy, nature

ENHANCING CLIMATE RESILIENCE IN MINING THROUGH AI-BASED LONG-TERM RAINFALL FORECASTING AND EXTREME EVENT ANALYSIS: A CASE STUDY OF THE OYU TOLGOI MINE

Khishigsuren Davagdorj^{1*}, Myagmarsuren Sanaakhorol¹, Bataa Dandarmaa²,
Munkhbold Bayarchuluun³, Regzedmaa Tsagaankhuu⁴

¹ *Technology and Data Services department, Asset Management division, Oyu Tolgoi LLC*

² *Environment department, Health, Safety, Environment, Security and Community division, Oyu Tolgoi LLC*

³ *Geotechnical Services, Surface Operations division, Oyu Tolgoi LLC*

⁴ *Tailings department, Surface Operations division, Oyu Tolgoi LLC*

* *Corresponding author: khishigsurend@riotinto.com or khishigsurend@chungbuk.ac.kr*

Abstract

Climate change is reshaping precipitation regimes, with long-term variability and extreme rainfall events emerging as critical risk factors for infrastructure-intensive sectors such as mining. The rising frequency and intensity of precipitation events present significant environmental and operational challenges, threatening infrastructure integrity, disrupting production, and increasing the likelihood of flooding. These shifting climate patterns underscore the urgent need for advanced forecasting capabilities and proactive risk mitigation strategies to enhance resilience and ensure sustainable operations. In this study, we develop an integrated framework that combines extreme weather event analysis with a deep learning-based precipitation forecasting model designed to predict rainfall at a weekly scale. The framework is applied to the Oyu Tolgoi copper-gold mine, located in Mongolia's South Gobi Desert, an arid region highly sensitive to rainfall variability. The model leverages daily satellite-derived precipitation data from the National Aeronautics and Space Administration (NASA) spanning 1981–2024 to generate week-of-year rainfall forecasts for the surrounding region. Results indicate a statistically significant increase in extreme weather events in recent decades, underscoring the need for adaptive planning in the mining sector. The proposed approach demonstrates the value of integrating satellite observations with artificial intelligence methods to improve environmental risk assessment and inform climate-resilient infrastructure design in mining regions exposed to hydrological extremes.

Keywords: Extreme rainfall events, LSTM based multi-Step forecasting, weekly precipitation forecasting, AI in hydrology, climate-resilient mining

ЗУРГААДУГААР ХЭСЭГ:

**ХАНАН ИЛТГЭЛИЙН
ХУРААНГУЙ**

МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ БА УЛСЫН НӨӨЦИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХАНГАМЖИЙН АСУУДАЛ

М.Бадамзаяа¹

¹ДХИС, ОБС-ийн Эдийн засаг, нөөц, ар талын тэнхим

*Холбоо барих зохиогчийн цахим хаяг: badamzaya89@gmail.com

Хураангуй

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр цаг агаарын таагүй нөхцөл байдал сүүлийн жилүүдэд мал аж ахуй эрхлэгчид, тариаланчдад сөргөөр нөлөөлж байна. Манай улсын хувьд бэлчээрийн мал аж ахуй нь эдийн засгийн уламжлалт салбар төдийгүй хүнсний хангамжийн гол эх үүсвэр юм.

Мал аж ахуйн салбарын гол эх үүсвэр бол бэлчээр юм. Бэлчээрийн даац хэтрэлт, бэлчээрийн талхагдал нь эмзэг, нимгэн хөрстэй манай Монголын газар нутагт цөлжилт нүүрлэхийн үндсэн шалтгаан болоод байна. Тодорхой нөхцөл, зүй тогтол, цаг хугацааны хэмнэлийн дагуу байгаль эх өөрийгөө нөхөн төлжүүлж, сэргэн амилж, эргээд үржил шимээ хайрладаг жамтай. Байгалийн энэхүү зүй тогтол газрын хөрсний шим тэжээл, бэлчээр, ургамалд ч мөн адил хамаатай. Бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглана гэдэг хөрснөөс дээш цухуйсан ургамлын навч найлзуурыг нөхөн төлжих чадваргүй болтол нь идэж дуусган, улмаар ургамлын үндэс нь үхжиж, бүрмөсөн устгаж байгаа нь эргээд уур амьсгалын систем сөргөөр нөлөөлж бэлчээрийн мал аж ахуйд ихээхэн хохирол учруулан Үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар аюул учруулж байна.

Зудын сөрөг үр дагавар нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбар бүрд, тэр дундаа хүн амын эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөн, хотжилт, ядуурал, ажилгүйдлийн түвшинд улмаар Үндэсний аюулгүй байдалд нөлөөлдөг нийтийг хамарсан гамшгийн төрөл юм. Одоогоос 24 жилийн өмнө буюу 2000, 2001 оны ган гачиг, зудад нэрвэгдсэний улмаас Монгол Улс тус бүр 10 сая мал хорогдож энэ нь нийт малын 22 хувьд хүрсэн нь 1944-1945 онд тохиолдсон зудаас хойш хамгийн хөнөөлт зуд гэж тооцогдон, малчид хотод ирж амьжиргааны эх үүсвэргүй болсныг бид мэднэ.

Мөн 2023-2024 оны өвөлжилтийн байдал хүндэрч, цаг агаарын тохиромжгүй байдлаас үүсэж 2024 оны 2 дугаар сарын 16-ны статистикийн мэдээгээр нийт нутгийн 80 гаруй хувь цас зудыг байдал бий болж, малын зүй бус хорогдол 2024 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 453.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 169.1 (59.4%) мянгаар өссөн байна. Малын хорогдол их гарч байгаа нь амьжиргааны эх үүсвэрээ алдаж ядуурлын эмзэг үед хүрээд байна.

Түлхүүр үг: Өвс, тэжээл, хангамж, бэлчээрийн даац, аюулгүй байдал

Судалгааны үндэслэл:

Дэлхийн уур амьсгалын дулааралт монгол нутагт нэн эрчимтэй илэрч байна. Монгол орны хэмжээгээр 1940-2018 оны хооронд жилийн агаарын дундаж температур 2.4°C-аар нэмэгдсэн нь дэлхийн дундаж 0.85°C-аас бараг 3 дахин байна. Энэ нь ган, зуд, үер бороо, салхи зэрэг цаг агаар-уур амьсгалын аюултай үзэгдлийн давтамж нэмэгдэхээс гадна, хэт халалтын давтамж түүний эрчим нэмэгдэх, газрын гадаргаас уурших, хөрсний чийгийн тэнцлийг алдагдуулан усны нөөц хомсдох, таримлын ургацын хэлбэлзэл ихсэх, ургамлын хортон шавжийн дэгдэлт болох зэрэг байгаль-нийгэм эдийн засгийн ихээхэн сөрөг үр дагавар дагуулж байгааг олон улсын болон үндэсний эрдэмтэн судлаачид 2019 оны байдлаар тогтоогоод байна [1].

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 71% нь бэлчээрийн зориулалтаар ашиглагддаг. Манай орны бэлчээрийн 70 орчим хувь нь ямар нэг хэмжээгээр талхлагдаж, зарим газарт цөлжилт эрчимтэй явагдаж байгаагаас бэлчээрийн ургац эрс багасаж, малд идэмж сайтай, тэжээлийн ач холбогдол өндөртэй ургамал хомсдож, мал иддэггүй ургамалд түрэгдэх аюул үүсээд байгаа энэхүү судалгааны үндэслэл болно [5].

Судалгааны материал, арга зүй:

Улсын нөөцийн газрын 1996-2024 он хүртэл малчдад олгосон өвс, тэжээлийн дүн, Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан мэдээ, Үндэсний Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, зэрэг тоон мэдээллийг харьцуулан судалгаа хийж “Swot” шинжилгээгээр давуу, сул тал боломж, аюулын зэргийг тодорхойлсон.

Судалгааны зорилго, зорилт:


Судалгааны зорилго нь уур амьсгалын өөрчлөлт ган, зуд, үер, салхи зэрэг цаг агаар, уур амьсгалын аюултай үзэгдлийн давтамж, мал аж ахуйн салбарт үзүүлэх нөлөө болон улсын нөөцийн өвс тэжээлийн хүрэлцээ хангамжид хэрхэн нөлөөлж буйг харуулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бэлчээр ашиглалтын зүй тогтлыг илрүүлэх
2. Монгол улсын бэлчээрийн даацад үзүүлэх нөлөөг тодорхойлох
3. Улсын нөөцийн өвс, тэжээлийн хангамж, хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох

Үр дүн:

Бэлчээрийн даац хэтэрсэн нутаг орны ургамал, хөрс хэрхэн доройтож, улмаар устаж үгүй болдог зүй тогтлыг эрдэмтэд ийнхүү тогтоожээ.

Бэлчээрийн ургамал хэт их ашиглалтын нөлөөгөөр хэрхэн доройтож устаж байгаа зүй тогтол



Жонсон, 1961

Зураг 1. Бэлчээрийн ургамал хэт их ашиглалтын нөлөөгөөр хэрхэн доройтож устаж байгаа зүй тогтол

Дээрх зурагт харуулснаар бэлчээрийн ургамлын навчны ашиглалт 50 хүртэл хувь байхад үндэс нь бараг гэмтэхгүй, хамгийн ихдээ 2-4 хувь гэмтэх магадлалтай бол 50-аас дээш хувиар давуулан ашиглахад үндэсний гэмтэл маш хурдацтай явагддаг байна. Мөн ургамлын навч найлзуурыг тасдаж гэмтээх явдал дээрх 50/50 харьцаанаас хэтэрвэл фотосинтез явагдахаа больж, ургамал нь шим тэжээлээр дутагдан, хэсэгхэн хугацаанд үндэснийхээ суурь шимээр тэжээгдэх боловч, улмаар үндэс нь мөн сульдаж, үхжиж эхэлдэг байна.

Бэлчээрийн даац хэмээх ойлголтын талаар янз бүрийн тодорхойлолт байдаг. Нийтлэг тодорхойлолт нь ашиглалтын хугацаанд бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжил, сэргэн ургах чадавх зэрэг төлөв байдлыг нь доройтуулахгүйгээр нэгж бэлчээрт буюу 100 га бэлчээрийн талбайд бэлчээж болох мал, амьтны тоо толгойгоор илэрхийлэгдэх үзүүлэлт мөн⁴.

Монгол Улсын бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ нь зах зээлийн эдийн засагт шилжих үе буюу 1989 онтой харьцуулахад 12.2 сая га-гаар (9.9%) буурчээ. Шилжилтийн 30-аад жилийн хугацаанд Монгол Улсын мал сүргийн тоо бараг 3 дахин, 100 га бэлчээрт ногдох малын тоо буюу бэлчээрийн ачаалал 2.3 дахин, малчдын тоо 2.2 дахин, нэг малчинд ногдох малын тоо 20 гаруй хувиар тус тус өссөн байна. (Хүснэгт 1). Эдгээр тоо баримт богино хугацаанд манай орны бэлчээрийн ачаалал асар их нэмэгдсэнийг харуулж байна⁵.


⁴ Цаг уур, орчны шинжилгээний газар <https://namem.gov.mn/>
Төслийн гарын авлага “Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал гарц ба шийдэл”, ”(БОАЖЯ, ХААИС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хөдөө аж ахуйн салбарын уур амьсгалын төсөл УБ. 2019) https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/Pastureland_Mongolia_Report.pdf
Гамигаас хамгаалах цагаан ном (Улсын нөөцийн газрын өвс, тэжээлийн хангалтын тоо баримт) УБ 2024 он

⁵ Цаг уур, орчны шинжилгээний газар <https://namem.gov.mn/>
Төслийн гарын авлага “Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал гарц ба

Хүснэгт 1. Монгол Улсын бэлчээрийн даац, ачааллын өөрчлөлт

№	Үзүүлэлт		1989	2018	Өөрчлөлт, (2018/1989)	
					Тоо	%
1	Бэлчээр, хадлангийн талбай, (сая га-гаар)		122.7	110.5	12.2	-9.9%
2	Малын тоо, бүгд (сая толгой)	бодит толгойгоор	24.7	66.5	+41.8	+2.7 дахин
		хонин толгойгоор	53.1	111.1	+58.0	+2.1 дахин
3	100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох малын тоо, (хонин толгойгоор)		43	100	+57	+2.3 дахин
4	Малчдын тоо, (мянган хүн)		135.4	288.7	+153.2	+2.2 дахин
5	Нэг малчинд ногдох малын тоо, (хүн)		182	230	+46	+26.4%

Монгол орны малын тоо, толгой 2019 он, 2022 онд хамгийн өдөр буюу 70 сая хүрсэн, мөн 2016-2022 он хүртэл тогтмол өссөн үзүүлэлтэй байна (Зураг 2).




Зураг 2. Монгол орны малын тоо, толгой 1996-2024 он

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан


Улсын нөөцийн газраас малчдад өвс хамгийн их буюу 2008-2009 оны зуднаар 24130,96 тн өвс олгосон, харин 2016-2018 онуудад өвс олголт бусад оноос харьцангуй жигд өндөр байгаа нь малын тоо, толгой өсөж бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотой байна (Зураг 3).

шийдэл”, ”(БОАЖЯ, ХААИС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хөдөө аж ахуйн салбарын уур амьсгалын төсөл УБ. 2019) https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/Pastureland_Mongolia_Report.pdf



Зураг 3. Улсын нөөцийн газраас олгосон өвс /тн

Улсын нөөцийн газраас малчдад тэжээлийн хамгийн их буюу 2018 онд 15853.87 тн тэжээл олгосон, харин 2016-2018 онуудад тэжээл олголт бусад оноос харьцангуй жигд өндөр байгаа нь малын тоо, толгой өсөж бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотой байна⁶. (Зураг 4).



Зураг 4. Улсын нөөцийн газраас олгосон өвс /тн

Хэлэлцүүлэг:

Мал аж ахуйн хөгжлийн тогтворгүй байдлыг засаж сайжруулах гол нөхцөлүүдийн нэг нь малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэн өсгөж, бэлчээрийн ачаалал, доройтлыг бууруулах арга зам юм. Байгалийн аясаараа байгаа бэлчээрийн ургамлын нөмрөг болон үржил шимт хөрс нүүрстөрөгч шингээн хуримтлуулагч чухал нөөцлөгчийн нэг болдог. Дэлхийн хэмжээнд нийт хээрийн бүс нүүрстөрөгчийн 20%-ийг хуримтлуулдаг ажээ. Бэлчээрийн ургамал нөмрөг доройтсоноор нүүрстөрөгч шингээгч бус, харин нүүрсхүчлийн хий ялгаруулагч эх үүсвэр болно.

Өөрөөр хэлбэл ургамал нөмрөгийн агаараас шингээж байгаа нүүрсхүчлийн

⁶ Гамигаас хамгаалах цагаан ном (Улсын нөөцийн газрын өвс, тэжээлийн хангалтын тоо баримт) УБ 2024 он.

хийн хэмжээ тухайн орчинд байгаа бүх амьд биетийн амьсгалаар ялгаруулж байгаа нүүрсхүчлийн хийн хэмжээнээс илүү гарахгүй байна гэсэн үг. Гэтэл ашиглалт зохистой байгаа бэлчээрт энэ үзүүлэлт эсрэгээр байна. Бэлчээрээ зохистой ашиглах нь мал сүргээ хамгаалах үндсэн нөхцөл төдийгүй уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад ч сайн нөлөө үзүүлнэ [6].

Дүгнэлт:

1. Судалгааны жилүүдийн Монгол Улсын бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ нь зах зээлийн эдийн засагт шилжих үе буюу 1989-2018 онтой харьцуулахад 12.2 сая га-гаар (9.9%) буурчээ. Шилжилтийн 30-аад жилийн хугацаанд Монгол Улсын мал сүргийн тоо бараг 3 дахин, 100 га бэлчээрт ногдох малын тоо буюу бэлчээрийн ачаалал 2.3 дахин, малчдын тоо 2.2 дахин, нэг малчинд ногдох малын тоо 20 гаруй хувиар тус тус өссөн байна.
2. Бидний судалгааны 1996-2024 оны улсын нөөцөөс өвс малчдад олголтоор хамгийн их буюу 2008-2009 оны зуднаар 24130,96 тн өвс олгосон, харин 2016-2018 онуудад өвс, тэжээл олголт бусад оноос харьцангуй жигд 30-50 %-иар өссөн нь ган зудын нөхцөлөөс бэлчээр хүрэлцээгүй, бэлчээрлэх боломжгүй байсантай холбоотой байна.
3. Улсын нөөцийн өвс, тэжээлийн хангамж, хэрхэн нөлөөлж буйг тодорхойлоход сүүлийн 30 жилийн хугацаанд зуд, ган байгалийн аюулт үзэгдлээс илүү Монгол Улсын малын тоо, толгой 2.3 дахин нэмэгдсэн, үүнийг дагаад бэлчээрийн ургамлын навчны ашиглалт 50% хүртэл буурсан нь өвс, тэжээлийн хангамжид нөлөөлөх гол шалтгаан болсон байна.

Ашигласан материал:

1. Бадамзаяа. М “Хөрсний үржил шимийн зарим үзүүлэлтэд үет ба буурцагт ургамлын нөлөө” (Докторын зэрэг горилсон бүтээл) УБ. 2024
2. Болдбаатар.Ш Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам. УБ.2015.
3. Цаг уур, орчны шинжилгээний газар <https://namem.gov.mn/>
4. Гамшгаас хамгаалах цагаан ном (Улсын нөөцийн газрын өвс, тэжээлийн хангалтын тоо баримт) УБ 2024 он
5. Төслийн гарын авлага “Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал гарц ба шийдэл”, ”(БОАЖЯ, ХААИС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хөдөө аж ахуйн салбарын уур амьсгалын төсөл УБ. 2019)
https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/Pastureland_Mongolia_Report.pdf
6. “Мал аж ахуйн хөгжлийн бодлогын шинэчлэлийн чиглэл, хэрэгжүүлэх зөвлөмж” гарын авлага УБ 2023 он
7. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://www.1212.mn/mn>

ХӨРСӨН ДЭХ ОРГАНИК НҮҮРСТӨРӨГЧИЙН НӨӨЦИЙГ ТООЦСОН ДҮНГЭЭС

*(Богдхан уулын Ар болон Өвөр Зайсан орчмын ногоон бүсийн
ойн хөрсний жишээн дээр)*

Бямбажавын Лхамсүрэн¹, Амарсанаагийн Сайнчулуу², Адъяазарын
Хишигсайхан³

¹ХААИС, Агроэкологийн сургууль, Экологийн тэнхим, Улаанбаатар хот,
Монгол улс, Lkhamasuren@mul.edu.mn

²ХААИС, Агроэкологийн сургууль, Экологийн тэнхим, Улаанбаатар хот,
Монгол улс, Sainchuluu@mul.edu.mn

³Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хот, Монгол улс,
Khishigsaikhan15@gmail.com

Хураангуй

Энэхүү судалгааны ажлын зорилго Богдхан уулын Өвөр болон Ар Зайсангийн амны ногоон бүсийн ойн хөрсний үржил шимийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа органик нүүрстөрөгчийн агууламж болон түүний нөөцийг судалж тогтооход чиглэсэн. Судалгааны хүрээнд рН, ялзмагийн агууламж, органик нүүрстөрөгч, солилцох сууриуд, фосфор, кали зэрэг үзүүлэлтүүдийг хөрсний 0–30 см гүнд сорьцлон шинжилсэн. Үр дүнгээс үзэхэд Өвөр Зайсангийн ойн хөрсний рН 5.20–5.80 (дунд зэргийн хүчиллэг), хумусын агууламж 8.1–14.1%, органик нүүрстөрөгч 4.7–8.2 %, харин солилцох сууриуд 10.50–70.00 мг, фосфор 0.81–1.49 мг, калийн агууламж 32.00–60.00 мг, Ар Зайсангийн хөрсөнд рН 6.08–6.70 (сул хүчиллэг), хумусын агууламж 7.0–12.5 %, органик нүүрстөрөгч 4.0–7.2 %, харин солилцох сууриуд 11.00–60.70 мг, фосфор 0.77–1.00 мг, калийн агууламж 37.50–81.00 мг тус тус байна. Хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийн хувьд Өвөр Зайсангийн ойн хөрсөнд 148.67 тн/га, Ар Зайсангийн ойн хөрсөнд 137.29 тн/га тус тус байна. Дээрх үр дүн нь тухайн бүс нутгийн хөрсний үржил шим болон нүүрстөрөгчийн нөөцийн төлөв байдлыг үнэлэх, цаашид экосистемийн үйлчилгээ болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг менежментийн арга хэмжээг оновчтой төлөвлөхөд чухал мэдээлэл болж өгөх ач холбогдолтой.

Түлхүүр үг: Ойн хөрс, хотын ногоон бүс, хөрсний органик нүүрстөрөгч, органик нүүрстөрөгчийн нөөц

Оршил:

Хөрс бол экосистемийн хамгийн чухал үндсэн бүрдэл хэсэг бөгөөд газар ашиглалт, суурьшил, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөгч байгалийн онцгой

нөөц юм [1]. Түүнчлэн хөрс нь дэлхийн органик нүүрстөрөгчийн хамгийн том агуулагч бөгөөд хуурай газрын ургамал болон агаар мандал дахь нүүрстөрөгчийн хэмжээнээс хэд дахин их нөөцийг агуулдаг [2]. Иймээс хөрсөнд агуулагдах органик нүүрстөрөгчийн өөрчлөлт нь дэлхийн нүүрстөрөгчийн эргэлт, уур амьсгалын өөрчлөлтөд шууд нөлөөлдөг байна [3]. Монгол Улс хөрсний органик нүүрстөрөгчийн нийт нөөцөөр дэлхийд 14-р байранд ордог бөгөөд Монгол орны хөрсний органик нүүрстөрөгчийн нийт нөөц 0-30 см гүнд 6553.1 Мт байна. Дунджаар манай улсын 1 га талбайн 0-30 см зузаан өнгөн хөрс 43.0 тн органик нүүрстөрөгчтэй байна. 0-100 см хөрсний органик нүүрстөрөгчийн нийт хэмжээ 9937.3 Мт, нэгж талбай буюу 1 га талбай (0-100 см) дунджаар 65.2 тн органик нүүрстөрөгчийн нөөцтэй байна [7].

Хот суурин газар орчмын ногоон бүсэд байгаль орчинд халгаатай олон үйл ажиллагаанаас үүдэн хөрс, хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэхээс гадна ургамлын зүйлийн бүрдэл хомсдож газрын доройтол нэлээдгүй нүүрлээд байна [4,5]. Ийм учраас эдгээр газруудын ногоон бүсийн ойг хамгаалах арга хэмжээг бодитой төлөвлөж, газар ашиглалтын оновчтой менежментийг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд бид Улаанбаатар хотын ногоон бүсийн тодорхой хэсгийг бүрдүүлж буй Богдхан уулын Ар, Өвөр Зайсан орчмын ногоон бүсийн ойн хөрсөн дэх органик нүүрстөрөгчийн агууламж, түүний нөөцийн хэмжээг тодорхойлох зорилго тавьсан.

Энэхүү судалгаа нь хот орчмын ойн хөрсний байгалийн чанарыг үнэлэх, ногоон бүсийн ойг хамгаалах болон нөхөн сэргээх үр дүнтэй менежментийн арга боловсруулахад үнэтэй суурь мэдээлэл болох юм. Уг судалгаатай ижил төстэй Монгол орны нөхцөлд өмнө нь хийгдсэн бусад судлаачдын судалгаануудаас үзэхэд ихэнх судалгаа Монгол орны ой, хээр, говь цөл болон нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн судалгаанууд байгаа боловч бидний судалгаанд хамрагдсан районд урьд өмнө нь энэ чиглэлээр хийгдсэн судалгаа ховор байна.

Судалгааны ажлын зорилго:

Богдхан уулын Ар болон Өвөр Зайсангийн амны ногоон бүсийн ойн хөрсөн дэх органик нүүрстөрөгчийн агууламж, нөөцийг судлан тогтоох.


Судалгааны ажлын зорилтууд:

- Судалгааны талбайн хөрсний үржил шимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Хөрсөн дэх органик нүүрстөрөгчийн агууламжийг тодорхойлох
- Органик нүүрстөрөгчийн нөөцийг тооцоолох

Судалгааны ажлын арга зүй:

Судалгааны объект Улаанбаатар хотын ХУД-ийн 14, 22-р хорооны нутаг

дэвсгэр, Богдхан уулын Ар болон Өвөр Зайсан орчмын ногоон бүсийн ойн 25 га талбай.



Ногоон бүсийн ойн хөрснөөс дээж авсан цэгүүд: P1, P2, P3, P4, P5, P6, P7, P8, P10
 Зураг 1. Судалгааны объект

Хөрсний морфологи шинж чанарыг тодорхойлох: Хөрсөнд зүсэлт хийж морфологи бичиглэл үйлдэн хөрсний хэв шинжийг тодорхойлсон.

Хөрсний агрегат бүтцийн хэмжээг тодорхойлох: Хөрсний бүтцийн хэмжээг Н. И. Савиновийн хуурай аргаар тодорхойлсон.

Хөрсний химийн үзүүлэлт:

Хөрсний урвалын орчинг Потенциаметрийн аргаар, хөрсний ялзмаг болон органик нүүрстөрөгчийг Тюрины бихроматын исэлдэлтийн аргаар, хөдөлгөөнт фосфор ба солилцох калийг Мачигины аргаар тус тус тодорхойлов.

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлт:

Хөрсний механик бүрэлдэхүүнийг-Качинскийн аргаар, хөрсний эзлэхүүн жин буюу нягтыг цилиндрээр жингийн аргаар, хөрсний чулууны агууламжийг массын аргаар тус тус тодорхойлов.

Ногоон бүсийн ойн хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийг тооцсон дүн
 Хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийг тооцоход дараах томъёог ашиглаласан.

$$SOC_{stock} = \sum_{i=1}^k Ri * Pi * Di (1 - Si) \sum_{i=1}^k Ri * Pi * Di (1 - Si)$$

SOC_{stock} – Хөрсний органик нүүрстөрөгчийн нөөц ($Kg\ m^{-2}$)

Ri – эзлэхүүн жин ($Mg\ m^{-3}$),

Pi- хөрсний органик нүүрстөрөгч (g C Kg^{-1}),

Di – үе давхаргын зузаан (m),

Si – 2 мм –ээс дээш чулууны эзлэхүүн (%)

Судалгааны ажлын үр дүн:

Судалгаанд хамрагдсан талбайн хөрс уулын ойн бараан хэв шинжийн хөрс байна.

Хүснэгт 1. Ногоон бүсийн ойн хөрсний агрохимийн шинж чанар

Дээж авсан гүн (см)	pH (H ₂ O)	Хумус, %	SOC, %	Солилцох сууриуд. мг- экв/100г		Шим тэжээлийн элементүүд. мг/100г	
				Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Өвөр Зайсан							
0–5	5.80 ± 0.53	14.14 ± 1.07	8.20 ± 0.62	70.00 ± 10.00	27.00 ± 0.01	1.49 ± 0.57	60.00 ± 12.00
5–10	5.25 ± 0.09	10.94 ± 1.04	6.62 ± 0.61	56.00 ± 6.00	24.50 ± 4.50	0.81 ± 0.16	32.00 ± 8.00
10–20	5.20 ± 0.02	10.30 ± 2.51	5.98 ± 1.46	36.00 ± 4.00	10.50 ± 3.50	0.77 ± 0.01	37.00 ± 1.00
20–30	5.26 ± 0.09	8.19 ± 2.26	4.75 ± 1.31	37.50 ± 7.50	13.50 ± 0.50	0.85 ± 0.12	37.00 ± 1.00
Ар Зайсан							
0–5	6.08 ± 0.09	12.57 ± 4.89	7.29 ± 0.95	60.75 ± 14.50	24.25 ± 6.72	1.00 ± 0.43	81.00 ± 32.39
5–10	6.28 ± 0.25	11.43 ± 0.64	6.35 ± 0.37	52.75 ± 8.58	17.50 ± 6.18	0.95 ± 0.23	66.00 ± 8.60
10–20	6.47 ± 0.24	9.81 ± 2.79	5.69 ± 1.62	46.50 ± 12.34	14.25 ± 5.54	0.77 ± 0.31	46.50 ± 4.56
20–30	6.70 ± 0.18	7.02 ± 2.27	4.07 ± 1.32	33.25 ± 4.82	11.00 ± 2.55	0.87 ± 0.04	37.50 ± 0.87

Дээрх үр дүнгээс үзэхэд Өвөр Зайсан амны хөрс харьцангуй хүчиллэг (pH 5.2–5.8) бол Ар Зайсангийн хөрс сул хүчиллэг (pH 6.1–6.7) шинжтэй байна. **Хөрсний** 0–5 см-ийн гүнд ялзмагийн агууламж өндөр (14.14 % ба 12.57 %), SOC 8.20 % болон 7.29 % байсан бол 20–30 см-ийн гүнд ялзмагийн агууламж 7–8 %, SOC 4–5 %-д буурсан байна. Энэ нь органик бодисын хуримтлал ихэвчлэн хөрсний дээд давхаргад төвлөрдгийг харуулж байна. Ca, Mg-ийн хэмжээ хөрсний гүнээс доошлохын хэрээр буурч, хамгийн ихдээ 0–5 см-ийн гүнд ($\text{Ca} = 70$ мг-экв/100 г, $\text{Mg} = 27$ мг-экв/100 г) илэрсэн. **Шим тэжээлийн элементүүдийн (P_2O_5 , K_2O) хувьд** Өвөр Зайсанд P_2O_5 хамгийн өндөр (1.49 мг/100 г) байхад, Ар Зайсанд K_2O 81 мг/100 г хүрсэн нь ялгаа илрэв. Гэвч аль алинд нь хөрсний доод үе давхаргад фосфор ба калийн хэмжээ буурч байсан. Эндээс үзэхэд бидний судалгааны талбай газар ашиглалт, экосистемийн нөхцөлтэй уялдаж хөрсөндэх органик нүүрстөрөгчийн (SOC) нөөцөд эдгээр хүчин зүйл шууд нөлөөлж байна гэж үзэх үндэстэй байна.

Хүснэгт 2. Ногоон бүсийн ойн хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийг тооцсон дүн

№	Дээж авсан газар	Дээж авсан гүн, см	n	SOCS, тн/га
Өвөр Зайсан				
1	Богдхан уулын Өвөр Зайсангийн ам	0-5	3	29.78
		5-10	3	23.27
		10-20	3	52.32
		20-30	3	43.30
Ар Зайсан				
2	Богдхан уулын Ар Зайсангийн ам	0-5	4	25.72
		5-10	4	22.87
		10-20	4	47.70
		20-30	4	41.00

Дээрх үр дүнгээс үзэхэд бидний судалгааны талбайн хөрсөндэх органик нүүрстөрөгчийн нөөц Өвөр Зайсангийн ойн хөрсний 0-30 см гүнд 148.67 тн/га, Ар Зайсангийн ойн хөрсөнд 137.29 тн/га байна. Энэ нь хоёр талбайн хооронд 11.38 тн/га-гаар зөрүүтэй байгаа бөгөөд Өвөр Зайсангийн хөрс илүү өндөр SOC-тэй болохыг харуулж байна. Өвөр Зайсангийн SOC-н илүү өндөр үзүүлэлт нь тухайн газрын хөрсөндэх органик нүүрстөрөгчийн агууламжтай уялдаж байна.

Дүгнэлт:

1. Өвөр болон Ар Зайсангийн амны ойн хөрс дунд зэрэг хүчиллэгээс сул хүчиллэг орчинтой бөгөөд органик нүүрстөрөгчийн агууламж (4.0-14.1 %) хооронд хэлбэлзэж байна. Өвөр Зайсангийн хөрсөнд органик нүүрстөрөгчийн агууламж (4.7–8.2%), Ар Зайсангийнхаас (4.0–7.2%) өндөр байгаа нь газар ашиглалтын онцлог ялгааг илтгэж байна. Энэ нь цаашид хөрсний үржил шим болон нүүрстөрөгчийн хуримтлалыг хамгаалах, нөхөн сэргээх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.
2. Судалгааны талбайн хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийг тогтоосон үр дүнгээс үзэхэд Өвөр Зайсангийн ойн хөрсний 0-30 см гүнд 148.67 тн/га, Ар Зайсангийнхад 137.29 тн/га тус тус байна. Энэ нь Монгол орны хэмжээнд 0-30 см өнгөн хөрсөнд (43.0 тн) органик нүүрстөрөгчийн нөөцөөс даруй 94.29-105.67 тн/га -аар илүү байна. Эндээс үзэхэд ойн хөрс органик нүүрстөрөгчийг их хэмжээгээр хуримтлуулдагтай холбоотойгоор, нөгөө талаас судалгаанд хамрагдсан газрын байгаль-уур амьсгал, ландшафтын ялгаанаас үүдэлтэй зөрүү илэрч байна.

Ашигласан материал:

- [1] Jobbágy EG, Jackson RB., “The vertical distribution of soil organic carbon and its relation to climate and vegetation,” Open Journal of Ecology, pp. 423-436, 2020.
- [2] Jenkinson, D. S., Adams, D. E., & Wild, A., “Model estimates of CO₂

- emissions from soil in response to global warming". *Nature*, 351(6324), 304-306, 1991.
- [3] Schlesinger, W.H. and Andrews, J.A., "Soil respiration and the global carbon cycle," *Biogeochemistry* 48, pp. 7-20, 2000.
- [4] Lal, R., "Managing soils and ecosystems for mitigating anthropogenic carbon emissions and advancing global food security," *Bioscience*, pp. 708-721, 2010.
- [5] Friedlingstein, P., Meinshausen, M., Arora, V. K., Jones, C. D., Anav, A., Liddicoat, S. K., & Knutti, R. (2014). Uncertainties in CMIP5 climate projections due to carbon cycle feedbacks. *Journal of Climate*, 27(2), 511-526.
- [6] FAO and ITPS, "Global Soil Organic Carbon Map V1.5," 2020
- [7] О.Батхишиг, "Монгол орны хөрсний органик нүүрстөрөгчийн нөөц," Монголын хөрс судлал сэтгүүл 6, pp. 6-14, 2021.
- [8] Б. Лхамсүрэн, Хөрс судлалд түгээмэл хэрэглэгддэг нэршил, нэр томъёоны тайлбар, Улаанбаатар, 2023
- [9] А. Хишигсайхан, "Хөрсөн дэх органик нүүрстөрөгчийн нөөцийг тооцсон дүн" сэдэвт магистрын зэрэг хамгаалсан бүтээл, 2024

ГОВИЙН БҮСИЙН УНДНЫ УСНЫ ХИМИЙН ШИНЖ, ХҮНД МЕТАЛЛЫН ЧАНАРЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д.Мандахцацрал¹, Б.Лхагвадулам²

¹ Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК

² ШУТИС, БАС, Хүрээлэн буй Орчны Инженерийн салбар

Хураангуй

Энэхүү эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг бид Монгол орны Говийн бүсийн 3 аймгийн 44 сумын 357 усны эх үүсвэр буюу ус хангамжийн худгийн усны хими,биологийн шинж чанар, хүнд металлын шинжилгээний үр дүнг ундны усны MNS0900:2018 стандарттай харьцуулан, стандартаас давсан үзүүлэлттэй худгуудад хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн үнэлгээг хийлээ. Үүнд Өдөр тутмын авах дундаж хэмжээ (ADD), Аюулын коэффициент (HQ), Нийт эрсдэлийн индекс (THI) гэх бөгөөд $THI > 1.0$ нь эрсдэл их байгааг, $THI \leq 1.0$ нь эрсдэлгүй болохыг тодорхойлов. Газрын доорх уснаас хоногт авах металлын хэмжээ (DIM), Эрүүл мэндийн эрсдэлийн индекс (HRI), Нийт эрсдэлийн индекс (THI) гэх бөгөөд $THI > 1.0$ нь эрсдэл их байгааг, $THI \leq 1.0$ нь эрсдэлгүй болохыг тодорхойлов. Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр физик, химийн үзүүлэлтээр 18.8%-ийн эрсдэлгүй, 81.2%-ийн эрсдэлтэй гарч байна. Ус хангамжийн худгуудад хүнд металлын эрсдэлийн үнэлгээ нь 26,82%-ийн эрсдэлгүй 73,18%-ийн эрсдэлтэй гарч байна.

Түлхүүр үг: Газрын доорх ус, ус хангамж, химийн үзүүлэлт, хүнд металлын үзүүлэлт эрсдэлийн үнэлгээ

Судлагдсан байдал:

Монгол улсад хот суурин газрын төвлөрөл буюу хотжилт хурдацтай хөгжиж байгаа хэдий ч уг үйл явц нь ихэнхдээ хот төлөвлөлт, хөгжлөөс гадуур явагдаж байгаа учраас анхаарлыг илүүтэй хандуулахад хүргэж байна. Хот суурин газар нь зөвхөн ус олборлох гол цэг төдийгүй хот суурин газрын усны эргэлт дэх усны чанар нь түүний ашиглалт болон цэвэрлэгээний байдлаас шалтгаалж байдаг.

Монгол орны өнөөгийн тогтоогдсон нөөцийн судалгааны дүнгээр газрын доорх усны нөөц нь хэрэглээний усны хэрэгцээг хангалттай хангах бололцоотой. Гэсэн хэдий ч хүн амын цаашдын өсөлт, хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбар хөгжихийн хэрээр газрын доорх усны олборлолт нэмэгдэх хандлагатай байна.

Хүнд металл, химийн (Cr, Cd, Hg, As, Zn, Cu, Fe, Al, Ba, Ca, Mg, Pb, Mn,

Ag, Na, Se) бохирдол нь амьд организмд маш их хортой байдаг. Гүний усанд агуулагдах зэс, цайр, селен нь хүнд шаардлагатай металлын тоонд ордог. Гэвч хар тугалга, хүнцэл, мөнгөн ус зэрэг металлын хувьд бага хэмжээгээр хэрэглэсэн ч хүнд маш аюултай байдаг. Хүний биеийн мэдрэлийн системийн гэмтэл, бөөрний дутагдал, цусны даралт, даралт ихсэх, чихрийн шижин, өсөлтийг дарангуйлах гэх мэт янз бүрийн өвчин нь ундны усны бохирдлоос үүдэлтэй байдаг.

Иймээс Ус хангамжийн худгуудын усанд эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн үнэлгээг хийх том сорилт тулгарч байна.

Фтор: Дэлхий даяар шүд цоорох өвчин буурах гол хүчин зүйл болсон. Гэсэн хэдий ч фторын хэт их хэрэглээ нь олон тооны сөрөг үр дагаварт хүргэдэг. Эдгээр нь өртөлтийн түвшин хугацаанаас хамаарч шүдний зөөлөн флюорозоос араг ясны флюороз, мэдрэлийн хоруу чанар, хорт хавдар үүсгэх, бамбай булчирхайн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Нитрат: Нярайн метгемоглобинемийн гаж нөлөөний түвшин болон жирэмсэн ээжийн нярайд бамбай булчирхайн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Нитратын эрүүл мэндэд үзүүлэх ноцтой нөлөөлөл нь богино хугацааны нөлөөнд суурилдаг. Нитрат нь байгалийн эх үүсвэр нь газар тариалан, ахуйн бохир уснаас усны орчинд ордог.

Хүнцэл: Хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд ихээр нөлөөлдөг чухал хүнд металл юм. Өдөр бүр 0,01 мг/л-ээс дээш хүнцэлтэй ус хэрэглэх нь үхэлд хүргэдэг байна. Хүнцэл нь цусны даралт ихсэх, мэдрэлийн систем, зүрх судасны тогтолцоонд ихээхэн нөлөөлөл үзүүлж, элэгний үйл ажиллагааг маш их хэмжээгээр гэмтээдэг байна. Хүнцэл нь хортой, хорт хавдар үүсгэдэг шинж чанартай ба дэлхийн 20 гаруй улсад өргөн тархсан байдаг.

Уран: Эрүүл мэндийн судалгаанаас үзэхэд их хэмжээний уран нь бөөрөнд гэмтэл учруулдаг байна. Байгаль дээр чулуулаг, хөрс, гадаргын болон гүний ус, агаар, ургамал, амьтанд байдаг цацраг идэвхт элемент юм. Хорт хавдар нь ихэвчлэн байгалийн ураны хордлогын үр дагавар биш юм.

Селен: Хүн, амьтанд зайлшгүй шаардлагатай шим тэжээл боловч их хэмжээгээр тогтмол хэрэглэвэл хортой байдаг. US/EPA стандартад ЗДХ-ээс дээш агууламжтай усыг богино хугацаанд хэрэглэсэн хүмүүст үс хумсны өөрчлөлт, захын мэдрэлийн системийг гэмтээх, ядрах, цочромтгой болох зэрэг эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Насан туршдаа селенийг ЗДХ-ээс дээш түвшинд байлгах нь үс хумсны алдагдал, бөөр, элэгний эд эсийг гэмтээж, мэдрэлийн болон цусны эргэлтийн системийг гэмтээж болно.

Судалгааны арга зүй:

Говийн бүсийн Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, дүгнэлт, зөвлөмжийг 44 сумын 357 ус хангамжийн худгуудын усанд агуулагдах хүнд металлын үзүүлэлтэд

хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв.

Олон улсын стандартууд:

Дэлхий нийтээр ус хангамжийн хэрэглээг стандарттай харьцуулан үздэг. Энэ нь ундны усанд хэрэглэж буй усыг хүний болон амьд бие организмын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор стандартыг тогтоож өгсөн гэж үздэг. Эрүүл мэндийг хамгаалах Аюулгүй байдал Ундны ус Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018, WHO болон USA,EPA стандартуудыг харьцуулав.

Үр дүн, дүгнэлт:

Энэхүү судалгааны үр дүнгээс 3 аймгийн 44 сумын 357 ус хангамжийн худгуудын усанд агуулагдах хими, биологи, хүнд металлын агууламж нь эрсдэлийн үнэлгээгээр хоногт хэрэглэх усны хэрэглээ, ундны усанд агуулагдах хими, биологийн агууламжаас шалтгаалан өсвөр насны хүүхдүүд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, бага насны хүүхдүүдэд эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ өндөр гарч байна.

Энэхүү эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээ хийснээр бид Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгааг үндэслэн ундны усны стандартын давсан үзүүлэлт бүхий хүнд металлын агууламжийг ундны усны стандартад нийцүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Дундговь аймагт Натри /Na⁺/-ын агууламж 50 дахин их эрсдэлтэй, Кальци /Ca²⁺/ 71 дахин их эрсдэлтэй, Фтор /F⁻/ 29 дахин эрсдэлтэй, Сульфат /SO₄²⁻/ 793 дахин их эрсдэлтэй, Нитрат /NO₃⁻/ 535 дахин их эрсдэлтэй, Хүнцэл /As/ 53 дахин их эрсдэлтэй, Уран /U/ 53 дахин их эрсдэлтэй, Стронци /Sr/ 8 дахин их эрсдэлтэй, Анзон /Mo/ 12 дахин эрсдэлтэй гарч байна. Дундговь аймагт Хүнцэл /As/, Уран /U/, Стронци /Sr/, Анзон /Mo/ хамгийн өндөр эрсдэлтэй байна. Дундговь аймагт Өлзийт сум, Эрдэнэдалай сумууд хамгийн өндөр эрсдэлтэй байна.

Дорноговь аймагт Хүнцэл /As/-ын агууламж 298 дахин их эрсдэлтэй, Стронци /Sr/ 39 дахин их эрсдэлтэй, Анзон /Mo/ 8 дахин эрсдэлтэй, Уран /U/ 140 дахин их эрсдэлтэй гарсан.Дорноговь аймагт Хүнцэл/As/, Уран/U/ хамгийн өндөр эрсдэлтэй байна.

Үүнээс дүгнэж үзэхэд хими, биологи, хүнд металлын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр Дорноговь аймагт Хүнцэл/As/, Уран/U/ хамгийн өндөр эрсдэлтэй байна.

Үүнээс дүгнэж үзэхэд газрын доорх усанд агуулагдах хими, биологи, хүнд металлын үзүүлэлт нь эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр Дорноговь аймагт Замын үүд сум, Сайншанд сумууд хамгийн өндөр эрсдэлтэй байна.

Өмнөговь аймагт Натри /Na⁺/-ын агууламж 62 дахин их эрсдэлтэй, Кальци

/Ca²⁺/ 33 дахин их эрсдэлтэй, Фтор /F⁻/ 131 дахин эрсдэлтэй, Сульфат /SO₄²⁻/ 2302 дахин их эрсдэлтэй, Нитрат /NO₃⁻/ 140 дахин их эрсдэлтэй, Хүнцэл /As/ 110 дахин өндөр эрсдэлтэй, Уран /U/ 5 дахин өндөр эрсдэлтэй гарч байна. Өмнөговь аймагт Хүнцэл /As/, Уран /U/ хамгийн өндөр эрсдэлтэй гарч байлаа. Өмнөговь аймагт Ханбогд сум, Ноён сум, Сэврэй сумууд эрсдэлтэй өндөр байлаа.

Иймд цаашид Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгааг үндэслэн газрын доорх усыг ундны усны стандартад нийцүүлэн хүн амын ус хангамжид хэрэглэх, цэвэрлэх технологийг оновчтой сонгон боловсруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

АДУУНЫ ХОМООЛООР ОРГАНИК БОРДОО БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН БОЛОМЖ БА АЧ ХОЛБОГДОЛ

Х.Энххэрлэн¹, Б.Эрдэнэцацрал²

¹ Дорнод аймгийн Байгаль орчны газар

² Дорнод аймгийн Баянтүмэн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал

Агуулга

Манай улсад хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Энэ нь зөвхөн төр засгийн үүрэг бус иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын асуудал болоод байна. Иймд хөдөөгийн сумдын хог хаягдлын тулгамдаж буй асуудлуудын нэг адууны хомоолыг дахин боловсруулан, хэмжээг бууруулах арга замыг эрэлхийлж, Дорнод аймгийн Баянтүмэн суманд “Бохирдлоор бид ногоон байгууламжийг шийднэ” уриатайгаар байгальд зүгээр хаягдан, бохирдол үүсгэж буй адууны хомоолыг ашиглан Япон улсын технологийн дагуу бордоо бэлтгэн, хэрэглэгчийн гар дээр хүргэхээр үйл ажиллагаагаа 2024 оноос эхлэн хэрэгжүүлж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна.

Түлхүүр үг: Уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдал, дахин боловсруулах, адууны хомоол, бордоо

Судалгааны зорилго:

Адууны хомоолыг задлан боловсруулж, шим тэжээллэг органик бордоо болгох технологийн боломж, үр өгөөжийг тодорхойлох.

Судалгааны арга зүй:

Ярилцлага, ажиглалтын арга: Бордоог үйлдвэрлэл буй арга барилыг судлахдаа “МСРТ” ХХК, “Эко тайхи” ХХК-ын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав.

Компостинг арга: Агааржуулалттай болон уламжлалт овоолгын аргаар адууны хомоолыг 90 хоногт боловсруулж, органик бордоог үйлдвэрлэв.

Лабораторийн шинжилгээ: Боловсруулж бэлтгэсэн бордоог “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд хөрсний химийн задлан шинжилгээг хийлгэсэн.

Судалгааны гол үр дүн:

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутаг дэвсгэрт сүүлийн жилүүдэд

эрчимжсэн мал аж ахуй буюу морины жүчээний тоо нэмэгдэж, 2024 онд 7 байршилд 600 гаруй адуутай байсан бөгөөд өдөрт 2,8 тн, жилд 1000 гаруй тн адууны хомоол хаягдал болон гардаг. Үүнтэй холбоотойгоор сумын төвийн хогийн цэг нь өмнө жилүүдэд 1-2 удаа шатаж, уугдаг байсан бол 2022 оноос эхлэн 3 улирлын турш гал гарч, шатах болон байнгын уугих байдалтай болсон. Үүнээс үүдэн агаарын болон орчны бохирдол үүсэж, гал түймэр гарах өндөр эрсдэлтэй болсон. Хогийн цэг шатах олон шалтгаан байдаг ч түгээмэл тохиолддог нь малын өтөг бууц наранд удаан байсан болон цогтой үнс, нурам хаяснаас болж гал гарах, уугих хамгийн том шалтгаан болдог. Тус сум нь 2024 онд сумын төвд байрлах хогийн цэгийг дарж булшлан, аймгийн нэгдсэн хогийн цэг буюу сумын төвөөс 35 км зайд тээвэрлэх болсноор сумыг тойрон зөвшөөрөлгүй хогийн цэгүүд үүсэж эхлээд байна. Мөн 2025 оны 5 сарын байдлаар тус сумын төвд 30 байршилд, 1300 гаруй адуу болон нэмэгдэж, сумын хэмжээнд өдөрт 6 тн, жилд 2190 тн адууны хомоол гарч, сумын нийт хог хаягдлын 15-20 хувийг адууны хомоол дангаар эзэлдэг гэсэн судалгаа гарсан байна.

Иймд бид хөдөөгийн сумдын хог хаягдлын тулгамдаж буй асуудлын нэг адууны хомоолыг дахин боловсруулж, хог хаягдлын хэмжээг бууруулах, органик бордоог үйлдвэрлэн ашиглах арга замыг эрэлхийлж байна. Мөн адууны хомоол нь бусад малын бууцнаас илүү нимгэн ширхэглэг бүтэц сайтай, хүнд үнэргүй, ялзралд амархан ордог, азот-фосфор-калийн агууламж өндөртэй тул бусад түүхий эдээс давуу талуудтай ба компост болгоход тохиромжтой байдаг.

Адууны хомоолоор органик бордоо боловсруулах технологийн боломж:

Монгол Улсын хэмжээнд органик бордоо үйлдвэрлэгч нийт 13 аж ахуйн нэгж байдаг бөгөөд тэдгээр нь өтөг бууц, хонины ноос, бактерийн бордоо, шингэн бордоо гэсэн дөрвөн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үйлдвэрлэгчдийг бордооны төрлөөр нь авч үзвэл органик бордоо үйлдвэрлэгчдийн тэн хагас нь шингэн болон бактерийн бордоог үйлдвэрлэж байна. Шингэн болон бактерийн бордооны хөрсөнд үзүүлэх үр нөлөө нь хатуу органик бордоотой харьцуулахад бага байдаг. Дотооддоо өтөг бууцаар бордоо үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийн бордоог гарган авахад ашиглаж буй түүхий эдээр нь авч үзвэл шувууны сангас, малын гаралтай хаягдал түүхий эд (хүүр, сэг зэм, үхрийн баас, үрц), малын бууц хөрзөн баас зэргийг ашиглан бордоог үйлдвэрлэдэг байна. Харин бид адууны хомоолыг ашиглан органик бордоог боловсруулахдаа Япон улсын технологийн дагуу агааржуулалттай, уламжлалт овоолгын аргыг ашиглаж байна. Үүнд:

Түүхий эд (адууны хомоол)ээ хово машинаар бордоо хийх газар луугаа 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр татаж, шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулсан. Технологийн гормын дагуу өтөг бууцыг өдөрт 3 удаа тогтмол цагт хэмжилтийг хийсэн. Ковш машинаар хөрсийг 18 хоногийн давтамжтай 3 удаа хөрсийг эргүүлэв. Өтөг бууцны температур 38-40 градус, 55% чийгшилтэй

байхад хэвийн урвалд орж байна гэж үзэн, түүнээс дээш байвал халалттай гэж үзэж усны машинаар услах ажлуудыг хийж гүйцэтгэн, 90 хоногт боловсруулж дууссан. Боловсруулж бэлтгэсэн бордоог “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд шинжилгээ хийлгэв. Туршилтын судалгааны үр дүн:

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн хээрийн чийг 15,36%, pH 8,11, давс 0,34%, ЦДЧ 0,699 dsm, ялзмаг 6,28%, NO_3 1,38 мг/100г, CaCO_2 0,16%, шингээгдсэн сууриуд Са 14,3 мг-экв/100 гр, Mg 10,0 мг-экв/100 гр, шимт тэжээлийн элементүүд P_2O_5 9,8 мг-100 гр, K_2O мг/100 гр гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Адууны хомоолоор органик бордоо боловсруулах ач холбогдол:

Адууны хомоол нь органик бодис агуулдгаараа химийн болон эрдэс бордооноос ялгаатай. Органик бодисын агууламжаасаа хамааран шим тэжээлийн бодисын урт хугацааны эх үүсвэр болж, хөрсний чанарыг сайжруулдаг. Харамсалтай одоогоор нь манай оронд адууны хомоолыг шим тэжээлийн бодисын чухал эх үүсвэр гэж үнэлж үзэхгүй байна. Адууны хомоолоор органик бордоог боловсруулахын ач холбогдол талаар авч үзье.

1. ***Байгаль орчинд ээлтэй шийдэл.*** Адууны хомоолыг дахин боловсруулах нь хөрс, усны бохирдлыг бууруулна. Хүлэмжийн хий ялгаралтыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд эергээр нөлөөлнө. Гал, түймэр гарахаас урьдчилан сэргийлнэ. Бордоог зах зээлд нийлүүлснээр орон нутгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
2. ***Хог хаягдлын хэмжээг бууруулах.*** Адууны хомоол нь тус сумын нийт хог хаягдлын 15-20 хувийг дангаараа эзэлдэг бөгөөд бордоо болгон ашигласнаар хог хаягдлын хэмжээг багасна (Эхний жилдээ 10 тн хомоолыг боловсруулна).
3. ***Хөрсний үржил шимийг нэмэгдүүлдэг.*** Органик бодисоор баялаг тул хөрсний бүтцийг сайжруулж, шим тэжээлийн тэнцвэрийг хадгалдаг. Чийг барих чадварыг нэмэгдүүлж, ургамлын ургалтыг дэмжинэ. Компост бордоо нь таримал ургамалд илүү тохиромжтой бөгөөд 20–30%-аар ургацын өсөлтийг нэмэгдүүлдэг.
4. ***Органик тариалангийн хөгжлийг дэмждэг.*** Химийн бордоог орлуулах эко шийдэл болж, органик тариалангийн үндэс суурь болдог. Органик бордоо нь ургамлын үндсийг түлэхгүй, хуримтлал үүсгэхгүй.
5. ***Эдийн засгийн үр ашиг.*** Үнэгүй түүхий эд ашигласнаар үйлдвэрлэлийн зардал бага. Бордоо болгон боловсруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг бий болгон, орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад нийлүүлэх боломжтой. Ажлын байр нэмэгдүүлж, сумын брэнд бүтээгдэхүүн болгож, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулна

(Одоогоор байнгын болон түр 5 ажлын байрыг бий болгоно).

6. **Нийгмийн ач холбогдол.** Малын гаралтай хог хаягдал нь хөдөөгийн сумдын нийтлэг асуудал тул адууны хомоолоор органик бордоог боловсруулах туршилтыг амжилттай хэрэгжүүлснээр сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Ингэснээр малчид, тариаланчдын байгаль хамгаалах ухамсрыг дээшлүүлэх, иргэдийн дунд хог хаягдлыг дахин ашиглах, органик хэрэглээг сонирхох хандлага нэмэгдүүлэх, мэдлэг, чадварыг дээшлүүлж, байгальд ээлтэй хэрэглээний соёл төлөвшүүлнэ. Залуучуудыг экологийн гаралтай бизнес, хөрөнгө оруулалтын чиглэл рүү татах, ногоон ажлын байр бий болгох суурь болно.

Дүгнэлт:

Адууны хомоол шим тэжээлийн хувьд харьцангуй өндөр агууламжтай бөгөөд ялзралын явц хурдан явагдсан. Компост хийхдээ малын хаягдал өвс, сүрэл, саадаг зэрэгтэй хольсноор бордооны бүтэц илүү сайжирдаг. Адууны хомоолыг 90 хоногт бүрэн боловсруулж, өндөр чанартай органик бордоо гарган авч болно. Органик бордоог боловсруулах нь эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд хор нөлөөгүй арга юм.

Адууны хомоол нь өндөр шим тэжээлтэй, биологийн хувьд идэвхтэй органик түүхий эд бөгөөд бордоо болгон дахин боловсруулснаар хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах, эдийн засгийн үр ашиг хүртэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Иймд адууны хомоолоор органик бордоо үйлдвэрлэх үйл явц нь зөвхөн хөдөө аж ахуйн нэг хэрэглээ бус, экологийн аюулгүй байдал, тогтвортой хөгжилд чиглэсэн стратегийн ач холбогдолтой шийдэл юм.

ХОВД ХОТЫН АМАРСАНААГИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД ТАРИМАЛЖУУЛСАН ЭМИЙН УРГАМЛЫН МАКРО, МИКРО ЭЛЕМЕНТИЙН СУДАЛГАА

Аюурзаны Амаржаргал¹, Гандалайн Золзаяа¹, Пүрэвдоржийн Мөнхзул¹

¹ МУИС-ийн Баруун бүсийн сургууль, Хими биологийн тэнхим

Хураангуй

Nepeta sibirica L нь Монгол орны Хангай, Их нууруудын хотгор, Говь-Алтай, Монгол-Алтай, Дорнод Монголын тойрогт ойт хээр, хээр, говийн бүсэд уулын хээр, голын нуга, голын сайр, нугажуу хажуу хад асгад ургана.

Nepeta sibirica L-ийг Түвдийн анагаах ухаанд халдварт өвчний үед биеийн ерөнхий эсэргүүцлийг нөхөн сэргээх, цөс, шээс хөөх зорилгоор хэрэглэдэг.

Мөн цагаан хорхой туулгах, цэр арилгах, астмын эсрэг, ариутгах, үрэвслийн эсрэг, амьсгалын дээд замын өвчнийг эмчлэх, уушиг, шээсний замын өвчлөл, үе мөчний өвчнийг анагаах, шүдний өвчин, ларингит, мэдрэлийн өвчнийг эмчлэхэд хэрэглэж иржээ.

2023 оны 7-р сард Увс аймгийн Хархираа уулнаас түүсэн *Nepeta sibirica* L-ийг байгалийн үрээр Ховд хотын Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн ашигт ургамлын саданд (N48°0.322', E 091°38.188') тарималжуулсан.

Судалгаанд ашигласан таримал *Nepeta sibirica* L-ийн дээжийг 2024 оны 7, 9-р сар, 2025 оны 3-р сард Ховд хотын Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн ашигт ургамлын саднаас цуглуулан бэлтгэсэн.

Ургамлын макро, микро, ультра микро элементийн хэмжээг рентген флуоресценцийн аргаар судлан тогтоосон.

Таримал *Nepeta sibirica* L-ийн морфометрийн хэмжилтийг 7 хоног бүр хийж гүйцэтгэн, судалгааны үр дүнг боловсруулахад SPSS программ хангамжийг ашигласан.

Таримал *Nepeta sibirica* L -ургамалд кальцийн оксид-25.19%, цахиурын оксид-22.83%, калийн оксид-6.94%, хөнгөн цагааны оксид-4.64%, фосфорын оксид-2.94%, магнийн оксид-6.49%, төмрийн оксид-2.07%, манганын оксид-0.082%, фтор->0.05%, шатаалтын хаягдал-22.72% агуулагдаж байна.

Ургамалд агуулагдах калийн ионууд нь фотосинтезийн үйл явцыг хэвийн болгох, эд эсийн механик хүчийг нэмэгдүүлэх, зарим өвчинд тэсвэртэй болоход чухал нөлөөтэй тул уг ургамалд /7-р сар/ нэмэгдсэн зүй тогтол ажиглагдав.

Цахиур, түүний оксид нь цэцэг үүсэх, үндэсний системийн үйл ажиллагааг сайжруулдаг нөлөө үзүүлдэг тул ургамалд /9-р сар/ нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна.

Түүнчлэн уг ургамалд /3-р сар/ цайр-1081мг/кг, зэс-80 мг/кг, бари-689мг/

кг, молибден-33 мг/кг, хар тугалга-33мг/кг, висмут-8мг/кг, мышьяк-14 мг/кг, ванади<15мг/кг, хром-45 мг/кг, никель-11 мг/кг, кобальт-7 мг/кг цагаан тугалга <30 мг/кг хэмжээтэй микро элементүүд, рубиди-33мг/кг, стронци-1158 мг/кг, циркони-58 мг/кг, иттри-12 мг/кг германи<30 мг/кг, цези<30 мг/кг, галли-3 мг/кг, цери<3 мг/кг, гафни<15мг/кг, лантани<30мг/кг, ниоби-6мг/кг, неодим<50 мг/кг, тантал<10 мг/кг, тори<10 мг/кг, самари<30 мг/кг, уран<5 мг/кг хэмжээтэй ультро микро элементүүд агуулагдаж байлаа.

Таримал *Nepeta sibirica* L-ургамалд циркони, рубиди, необи, иттри зэрэг элементүүд харьцангуй өндөр хэмжээтэй агуулагдаж байна.

Ургамалд рубидийн хэмжээ-33мг/кг байгаа тул амин хүчлийн нийлэгжилт, калийн солилцоонд чухал үүрэгтэй. Ургамалд 58 мг/кг циркони агуулагдаж байгаа тул навчинд ус дутагдахаас сэргийлэх үйлдэл үзүүлнэ.

Nepeta sibirica L нь 2025 оны 3-р сарын 30-ны байдлаар ургамлын дундаж өндөр-39.20±3.35 см, дундаж диаметр -25.30±3.65 см, 2025 оны 5-р сарын 04-ны байдлаар ургамлын дундаж өндөр-40.55±2.66 см, дундаж диаметр-22.70±2.17 см, 2025 оны 6-р сарын 8-ны байдлаар ургамлын дундаж өндөр-55.9±2.85 см, дундаж диаметр-42.75±2.13 см, 2025 оны 7-р сарын 4-ны байдлаар ургамлын дундаж өндөр-59.15±4.87 дундаж диаметр-29.05±2.94 см болж нэмэгдсэн нь ургамал байгалийн үрээрээ сэргэн ургаж байгааг илтгэж байна. Иймээс энэ ургамлыг уул уурхайн нөхөн сэргээлт хийх, хотын цэцэрлэгт хүрээлэнд тарималжуулж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

Ургамлын германи, цези, тантал, вольфрам, уран, самари, неодим, гафни, рубиди, лантан, сурьма, скандийн хэмжээ нь Олон улсын цацрагийн хамгаалалтын комиссын (ICRP) лавлагааны шаардлагыг хангаж байгаа тул ил талбайд тарималжуулахад хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Nepeta sibirica L ургамалд зэс, цагаан тугалга, кадми зэрэг хүнд элементийн хэмжээ нь ургамалд агуулагдах стандарт хэмжээнээс хэтрээгүй тул ил талбайд тарималжуулахад хүн ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Түлхүүр үг: *Nepeta sibirica* L, эмийн ургамал, элементийн найрлага, морфометрийн судалгаа

МОНГОЛЫН ГОВИЙН ЦӨЛЖИЛТИЙН ТАЛААРХ СУДАЛГАА, БОДЛОГО, ШИЙДЭЛ, ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА

К.Алтынбек¹, Х.Дондог²

¹ Хөгжлийн Шүтэлцээ НҮТББ, Удирдах Зөвлөлийн гишүүн

² Хөгжлийн Шүтэлцээ НҮТББ-ын судлаач

Судалгааны зорилго:

Монголын говь цөл нутгийн олон улсын судалгаа-мэдээллийн баазыг монгол ахуйн уламжлалт танин мэдэхүйн мэдээллээр баяжуулан ерөнхий дүр зургийг гаргах, орон нутагт тохирсон цөлжилтийн эсрэг бодлого, арга хэмжээг тодруулахад оршино.

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгаа нь **тоон болон чанарын аргуудыг** хослуулан монгол говийн талаарх гадаад дотоодын судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэж, хиймэл дагуулын мэдээллийн боловсруулалтын алдааны интервалын хүрээнд алдагдаж буй мэдээллийг нь тодруулсан. Алсын зайн мэдрэгч, газрын мониторинг ашигласан, цаг уурын урт хугацааны өгөгдөлд тулгуурласан, малын тоо, бэлчээрийн статистик мэдээллийг ашигласан, бодлого, хөтөлбөрийн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн, орон нутгийн мэдлэг, экологийн онцлогийг харгалзсан зэрэг нь бидний судалгааны аргын давуу тал болно.

Үр дүн:

Уламжлалт “цөлжилт” парадигмын хүрээнд авч үзвэл, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 76.9% нь цөлжилтөд өртсөн бөгөөд 23.3% нь хүчтэй, маш хүчтэй түвшинд байна. Цөлжилт нь зөвхөн байгалийн бус, хүний үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой доройтол юм. Температур 2.24 °C нэмэгдэж, хур тунадас 7% буурсан нь экосистемд дарамт үүсгэж байна. Төрийн зүгээс авч буй арга хэмжээнүүд, тухайлбал тусгай хамгаалалт, үндэсний хөтөлбөр, ойжуулалт, бэлчээрийн менежмент зэрэг нь зарим нутагт нааштай нөлөө үзүүлж байна. Бидний судалгаагаар 1990 оноос хойш малын тоо эрс өсөж, малчин өрхийн тоо дунджаар 230 мянга орчимд тогтвортой байгаа нь бэлчээр нутаг усны далд нөөцтэй холбоотой байна.

Ач холбогдол:

Энэхүү судалгаа нь цөлжилт, газрын доройтлыг говь нутагт шинээр гэнэт үүссэн үзэгдэл мэтээр авч үзэхгүй байх шинэ хандлагын санааг онцолж

байна. Говь бол унаган төрхөөрөө хэт хуурай, халуун, ургамал таруу, бас тачир боловч говийн онцлог амьдралыг тэтгэхэд хүрэлцээтэй байсан, цаашид ч байх боломжтой юм. Иймд говийн байгалийн унаган динамикт тохирсон ямар ашиглалт, зохицуулалт, орчин үеийн техник технологийн шийдэл олж хэрэгжүүлэх нь хөгжлийн гарц байх вэ? Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд уламжлалт мэдлэг тээгч малчдыг “төлөвлөгч” хэлбэрээр оролцуулах нь хэр үр нөлөөтэй вэ? зэрэгт хариу шийдлийг өгөхдөө “Нутаг ус” парадигмын хүрээг ашиглах болно.

Түлхүүр үг: Уламжлалт мэдлэг, нутаг индекс, нутаг ус, говийн байгалийн унаган динамик

ГОВИЙН БҮСЭД АГААРЫН ЧИЙГИЙГ АШИГЛАН ҮҮСГЭМЭЛ ГРУНТИЙН УСТ ДАВХАРГАТАЙ ХУУРАЙ САЙРЫН ДАЛАН БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Ганбаатар Соджавхлан¹, Наранцогт Насанбаяр¹

¹ ШУТИС, Барилга архитектурын сургууль, Инженерийн байгууламжийн салбар, Улаанбаатар, Монгол

Хураангуй

Үерийн жилийн давтамж болон орох хур тунадасны хэмжээ эрс нэмэгдэж буй сүүлийн жилүүдэд байгалийн тогтоц бүхий тойрмыг ардын хөв цөөрмөөр хуримтлуулан нөхөн сэргээгдэх, хэрэглээний усны эх үүсвэр болгох нь ихэссэн ч бэлчээрийн болоод байгалийн тогтоц, улирлын зөрүүнээс шалтгаалан иргэдийн хэрэглээг бүрэн хангах боломжгүй байна. Иймд дээр дурдсан хүчин зүйлүүдийг үл хамааран аль ч цаг үед, агаарын чийгшлийг хөргөх, ус гаргаж авах технологийг усны барилга байгууламж бүхий хөв цөөрөмтэй хослуулан байгуулах нь усны эх үүсвэрийн хомсдолд орсон говийн бүс нутагт хамгийн хэрэгцээтэй агаад тохиромжтой шийдэл болно. Улирлын чанар агаарын чийгшлийн нөлөөгөөр гарцын хэмжээ хэлбэлзэх боломжтой ч гадаргын болон газрын доорх ашиглах боломжит усны нөөцийг урт хугацаандаа нэмэгдүүлэх, аймаг сумдын засаг захиргаад, усны экологи-эдийн засгийн үнэлгээнд тулгарах дарамтыг бууруулахад оруулах хувь нэмэр нь байнгын ундарга бүхий жижиг булагтай дүйцэхүйц байна.

Түлхүүр үг: Агаар, байгууламж, говь, хуримтлуулах, чийгшил

Удиртгал:

Агаар мандал дахь агаарын чийгшил гэдэг нь ургамлын транспирац, амьсгалын замын ууршилтаас эхлүүлээд гол, нуур, далай, хөрс, гэх мэт байгаль орчны конденсацлагдах үзэгдлээр эргэлдэж, нөхөн сэргээгдэж, байнгын өөрийгөө сэлбэж, цэвэршүүлдэг, хий хэлбэрт оршин буй үл шавхагдах усны нөөц мөн болно [1].

Говийн бүс нутагт хур тунадас, нуур цөөрмөөр нөхөн сэргээгддэг, сэргээгдсэн тохиолдолд хэдэн мянган жилээр тооцогддог газрын доорх усны ашиглалтын нөөц нь байгалийн үнэт баялагт зүй ёсоор багтана. Гэвч тус аймагт гадаргын усны томоохон нөөц хомс тул динамик ашиглалтын нөөц буюу газрын доорх усны ашиглалтын нөөцийг шавхан ашиглахаас өөр боломжгүй байгаа юм. Энэ асуудалд тулгуурласан “уатэр сийр” агаарын чийгшлээс ус гарган авах технологийг Монгол орны байгаль орчны зохилдлогоонд нийцүүлэн гарцын

хэмжээг нэмэгдүүлж, үерийн усыг хураан авах зориулалттай байгууламжийн ууршилтыг ашигтай байдлаар хувирган байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр уст цэг бүтээн хэрэглэгчид хүртээх арга замаар инновацлаг шийдэл дэвшүүлсэн болно.

Энэ төхөөрөмж нь говь цөл дундах баян бүрдийг бүрэлдүүлэгч хүчин зүйлсийн нэг буюу агаарын чийгшлийг татаж, шингэн төлөвт хураан, урсгах үүрэг бүхий агаар мандлын конденсацлагдах үзэгдлээс сэдэвлэгдэн бүтээгдсэн болно. Монгол орны хувьд Өмнөговь аймгийн Сэврэй суманд байршилтай Хонгорын гол, Завхан аймгийн Эрдэнэхайрхан суманд байршилтай Мухартын гол гэх мэт нь байнгын ундаргатай булаг бүхий газрууд нь энэ боломж хэрэгжих магадлалтайг баталсан байгалийн тогтоц бүхий томоохон судалгааны бодит жишээнүүд мөн болно.

Зорилго:

Хур тунадас багатай бүс нутгуудад баригдсан төмөр бетон болон шороон боомтууд цаг уурын өөрчлөлтөөс хамааран байнгын урсацтай байх нь ховор тул шинээр баригдаж буй болоод урсац багатай хуурай сайр бүхий боомтуудад “уатэр сийр” төхөөрөмжтэй ижил төсөөтэй байдлаар грунтийн уст давхарга үүсгэдэг (sand dam) элсэн боомттой жишин “хуурай сайрын далан” болгон шинэчилж, дээр дурдагдсан төхөөрөмжтэй хослуулан ашигласнаар хур борооны болоод агаарт оршин буй усыг хэрэглээнд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, алсын зорилгодоо газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Уг байгууламжийн гарцыг усны шинжилгээнд хамруулснаар ундны усанд ч ашиглах боломжтой нөхөн сэргээгдэх нөөц бүхий уст цэгийг бүтээх нь энэ өгүүллэгийн зорилго болно.

Зорилт:

Байнгын хэлбэлзэлд оршин хурдацтайгаар өөрчлөгдөж байдаг тус биетийг олборлож хуримтлуулахад гарах улирлын чанартай сул зогсолт ,цаг тутамд өөрчлөгдөх чийгийн хэмжээ ,температурын огцом зөрүү ,шороон шуурга гэх мэт гэнэтийн байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд нь туршилт хийж эхлэхээс өмнөх тооцооны хариу болох гарцын хамгийн их утга, хамгийн бага утгаас түр хугацаанд зөрүүтэй үр дүн үзүүлэх магадлалтай тул өгөгдсөн байршлуудад туршилт явуулах нь нэн тэргүүний зорилт мөн болно.

Технологи ба онол:

Төвөөс зугтах сэнс: Төвөөс зугтах сэнс нь агаарын урсгалыг өөртөө татан төхөөрөмж рүү оруулах зарчмаар гарцыг нэмэгдүүлэх үүрэг бүхий босоо тэнхлэгт эд анги мөн болно. Салхины даралтын алдагдал, эргэлтийн эрчим сулрах , сөрөг урсгалаас үүдэлтэй энергийн алдагдлаас сэргийлэхийн тулд ирний

тоо, өнцөг салхины тусгалыг орон нутгийн олон жилийн дундаж мэдээллээр үндэслэж ашигт үйлийн хувь хамгийн өндөр байхаар бодолцох шаардлагатай тул олон тоогоор үйлдвэрлэх хэрэгцээ тулгарсан үед нэг бүрийн хэлбэр хэмжээ харилцан адилгүй байна. Иймд заагдсан газарт олон тоогоор байршуулахаас илүүгээр гарцын хэмжээг тодотгон авч үзсэн болно. Үүнийг сонгон суурилуулах ирний урт, газрын гадаргаас дээших өндөр, ерөнхий бүтцийг тодорхойлох болон ашиглалтын явцад хүлээн авах боломжтой салхины даралтын хэмжээ зэргээрийг оновчтой тооцоолох үүднээс Олон Улсын Цахилгаан Техникийн Комиссоос (IEC) тодорхойлсон салхин турбины ангилалтай жишив. [2]

Салхин Турбин: Салхин Турбин нь төхөөрөмжийн оройн хэсэгт байрлаж механик ажиллагаагаар төвөөс зугтах сэнсний эргэлтийн тоо, чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий анхдагч салхи хүлээн авах хэсэг байна. Тус эд анги нь салхины кинетик энергийг цахилгаан эрчим хүч болгон хувиргаж хөргөлтийн системийг хангах, конденсацод оролцож чийгээ алдсан агаарыг сорон гаргах үүргийг давхар хүлээнэ.

Салхины эрчим хүчний нягтрал (WPD) буюу тодорхой хэсгийг нэгж хугацаанд дамжин өнгөрөх энергийн хэмжээнээс салхин турбины эргэлтийн тоо үйлдвэрлэх боломжтой цахилгаан эрчим хүчний хэмжээ шууд хамааралтай. Иймд Салхины эрчим хүчний нягтралын мэдээллийг газар зүйн өгөгдлөөр боловсруулан өгөөж ихтэй боломжит байршлуудыг тодорхойлох нь нэн тэргүүний ажил мөн. (3)

Дамжуулах хоолой буюу тулгуур багана. Дамжуулах хоолой буюу тулгуур багана нь хоёр төрлийн металлаас бүрдэнэ. Эхний металл буюу зэвэрдэггүй ган нь өнгөн хөрсний ёроолоос эхэлж толгой сэнс хүртэл байрших агаад төвөөс зугтах сэнснээс түрэгдэн ирж буй салхийг дамжуулан өнгөрөөх үүрэгтэй бол хоёр дахь металл болох зэс хоолой нь өнгөн хөрснөөс доош конденсацгийн танк хүртэл үргэлжилж хөргөлтийн системийн нэгэн хэсэг хэлбэрээр ажиллан дулаан дамжуулах өндөр чадвараа ашиглаж дамжин өнгөрөх агаарын хэмийг бууруулах зорилготой хэсэг мөн болно.

Тус хоёр металл нь нэгэн бүхэл байх агаад тулгуур баганын үүргийг хослон гүйцэтгэнэ. Бүрэлдэхүүн хэсгийн дулаан дамжуулах чадварыг “Nusselt number” (Nu) ээр тодорхойлов

Арга зүй:

Өмнөх оролдлого. Амьд биет болон хүрээлэн буй орчноос ууршиж байгаа усны уур бол байгаль ертөнц өөрийгөө цэвэршүүлж экосистемийн тэнцвэртэй байдлыг хангаж байгаа нэгэн тод жишээ мөн. Усны ууршилтаар зөвхөн усны молекулууд ялгарч агаарт дэгддэг учир тус усны нөөц нь эрдэсжилт ,бохирдол ,бичил биетнээс ангид оршдог [1].

Хэдий агаарын чанар, ашиглалт засвараас хамааран усны чанар өөрчлөгдөх

хэдий ч хамаарал бүхий зүйлсийг болон техникийн үзлэг засварыг тогтсон хугацаанд болоод сул зогсолтын дараа хийж гүйцэтгэснээр гадаргын уснаас тодорхой хэмжээний илүү цэнгэг хэрэглээний усны нөөц болох боломжтой. Байнгын шинжилгээ ажиглалтын үр дүнд ундны усанд ч хэрэглэх бүрэн боломжтой дээр цахилаан тэжээл бүхий хөргүүргүй байсан ч энгийн механик ажиллагаагаар тасралтгүй ажиллах зохицуулалтайгаар [4] тусгаж өгснөөр Монгол орны эрс тэрс уур амьсгалд зохицох үндэс болсон.

Элс ,сайр нь шүүрүүлэх чадвар өндөртэй тул урсан орж ирэх үерийн болоод хур борооны усыг саадгүйгээр өөртөө нэвтрүүлнэ[5]. байгалийн тогтоц бүхий жалга суваг дагуу элсэн боомтыг байршуулснаар үерээс хамгаалах байгууламж болохын сацуу үерийн уснаас бичил биетэн шавж хорхойг шүүж үлдээх үүргийг давхар гүйцэтгэдэг .Одоо байгаа урсац багатай боомтуудын дээд болон доод хэсэгт ус үл нэвтрүүлэх хучлага тавих нь зардал өндөртэй дээр ууршилтаас төдийлөн хамгаалж чадахгүй тул эдгээр сайруудыг элсэн боомт болгон хувиргаж, байнгын урсацгүй гэх асуудлыг төхөөрөмжөөр шийдвэрлэх нь хамгийн оновчтой шийдэл мөн болно.

Үр дүн:

Төхөөрөмж ба элсэн боомт. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын угтах үдэх хаалганаас хойш 4.3км зайд байршилтай нутгийн нэршлээр Бор хужрын хоолой хэмээх газарт туршилт байдлаар тооцоолж үзэхэд

5-6 сард хоногт дунджаар 200 литр

7-р сард хоногт дунджаар 243 литр

8-р сард хоногт дунджаар 220 литр

9-р сард хоногт дунджаар 130 литр

Усыг агаарын чийгшлээр үйлдвэрлэх боломжтой. Тус үр дүн нь элсэн боомтын хураан ууршуулах чийгшлийн хэмжээг тооцоогүй болно. Элсэн боомт нь цугларсан ус нэг дор их хэмжээгээр ууршихаас сэргийлэх тул орчин буй байгальдаа ургамал ургахад таатай нөхцөлийг бүрдүүлэх , агаарын чийгшлийг тогтмол хэмжээнд нэмэгдүүлэн барих учир бага хэмжээний борооны дараач гэсэн ойрын өдрүүддээ төхөөрөмжийн гарцыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Энэ газарт урсан ирэх 1 хувын хангамшилтай урсац буюу хамгийн ихдээ үерийн 5400м³ усыг элсэн боомтоороо хуримтлуулах боломжтой байна.

Дүгнэлт:

Урьдчилсан тооцооллын үр дүнд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт 5 сараас 10 сар хүртэлх урин дулааны улиралд хоногт дунджаар 193литр усыг агаарын чийгшлээс гарган авах боломжтой байна. Үүнийг алслагдсан хөдөө орон нутагт элсэн боомт эсвэл одоо баригдсан байгаа үерээс хамгаалах байгууламжтай хослуулан ашигласнаар үерийн усыг хураан

хуримтлуулах, түүнийгээ хэрэглээний усанд ашиглах боломжтой нөөц болгох , усалгаа болоод байгаль орчныг нөхөн сэргээх байнгын урсац бүхий уст цэг , баян бүрд болгож малчин иргэдийн гүний усны хэрэглээг багасгах , зэрлэг амьтадыг усжуулах чадамж бүхий төвлөрсөн түшиц газрыг харьцангуй бага төсвөөр, богино хугацаанд бүтээн байгуулах боломжтой байна.

Ашигласан материал:

1. <https://www.wwdmag.com/what-is-articles/article/10940138/what-is-water-distillation?utm>
2. S. Hanish Anand, J.Antony Freegen, A.Arun, R.Jagan, R.Suresh,” DESIGN AND FABRICATION OF WATER SEER”
3. Global Wind Atlas
4. Lucia Cattani, Anna Magrini, PaoloCattani, ”Water Extraction from Air: A Proposal for a New Indicator to Compare Air Water Generators Efficiency”
5. Principles of Geotechnical Engineering” – Braja M. Das

СУРАГЧДЫН МАНЛАЙЛАЛД СУУРИЛСАН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЦӨЛЖИЛТИЙН ЭСРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ БУЙ НЬ

С. Дуламсүрэн¹

¹ Завхан аймаг Шилүүстэй сумын ЕБС

Зорилго:

Монгол орны хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны нөөцийн хомсдол зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлууд хурцдаж байгаа өнөө үед байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна. Гэвч эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, байгаль хамгааллын байгууллагуудын үйл ажиллагаа дангаараа хангалтгүй бөгөөд иргэдийн хандлага, оролцоо шийдвэрлэх үүрэгтэй болсон. Тиймээс энэхүү судалгаагаар сургуулийн ЭКО клубын хүрээнд сурагчдын манлайлалд тулгуурлан зохион байгуулсан нөлөөллийн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн байгаль хамгаалал дахь оролцоонд хэрхэн эерэг нөлөө үзүүлж байгааг тодорхойлох, түүнчлэн хүүхдийн боловсрол, оролцоо нь цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж болох бодит жишээг тогтоох зорилготой.

Арга зүй:

Судалгаанд чанарын болон тоон судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Арга зүйн хувьд ажиглалт, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, асуулга, оролцогчдын үнэлгээ, баримт бичгийн аргуудыг ашигласан. Судалгаанд Шилүүстэй сумын ЕБС-ийн “Бид байгалийн найзууд” ЭКО клубын 30 сурагч, ахлах ангийн 90 орчим сурагч, 80 орчим орон нутгийн иргэн, 60 гаруй эцэг эхийг хамруулсан. Үйл ажиллагаанд оролцогчдын дундаж нас, боловсролын түвшин, байгаль орчны талаарх өмнөх мэдлэг, хандлагын өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийг тооцож, мэдээллийн цуглуулалт, боловсруулалт, шинжилгээ хийсэн. Түүнчлэн сургуулийн болон айл өрх, сумын төвд хийгдсэн мод тарих, хог ангилах, мэдээлэл түгээх зэрэг нөлөөллийн ажлуудын цар хүрээ, чанарыг баримтжуулсан.

Үр дүн:

Судалгааны үр дүнд дараах гол ажиглалтууд гарсан:

1. **Сурагчдын манлайлал бодитоор хэрэгжиж, бусдыг уриалан дуудаж байна.** ЭКО клубын сурагчид 2022 оноос эхлэн багшийн чиглүүлэгтэйгээр нөлөөллийн олон ажлыг бие даан зохион байгуулжээ. Жишээлбэл,

“Хашаандаа мод тарья” аяны хүрээнд 200 гаруй мод, бут сөөг сургууль болон айл өрхүүдийн хашаанд тарьсан нь цөлжилттэй тэмцэхэд чиглэсэн үр дүнтэй үйлдэл болсон. “Хогоо ангилъя” аяны хүрээнд сургуулийн орчин, сумын төвийн хогийн савнуудыг төрөлжүүлж, ангилан ялгах уриалга бүхий постер, зурагт хуудсыг сурагчид өөрсдөө гаргасан болно.

2. **Олон нийтийн хандлага, оролцоонд эерэг өөрчлөлт орсон.** Иргэдийн хувьд байгаль орчны асуудлыг “төрийн хийх ажил” гэж үздэг хандлагаасаа аажмаар татгалзаж, хүүхдүүдийн санаачилга, тууштай байдалд хүндэтгэлтэй хандаж эхэлсэн. Эцэг эхчүүд хүүхдүүдээ хашаандаа мод тарих санаачилгыг дэмжиж хашаандаа мод тарьж, ашигласан зайгаа ангилан өгөх, хог хаягдлаа ангилах, дахин ашиглах арга замыг судлах, хэрэгжүүлэх зэргээр эерэг байгальдаа ээлтэй хандлага бий болж эхэлсэн.
3. **Мэдээлэл түгээх, цахим хэрэглээг зөв ашиглаж чадсан.** Сурагчид цахим постер, уриалга, “ашигласан зайгаа хийгээрэй” “Ундааны савны бөглөө хийх” гэсэн хайрцаг байрлуулах зэрэг мэдээлэл түгээх шинэлэг хэлбэрийг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ нь хүүхдүүд өөрсдөө зөв мэдлэг, мэдээлэлтэй болохын зэрэгцээ бусдад нөлөөлөх, нийгмийн хариуцлагатай иргэн болон төлөвшиж байгааг харуулсаар байна.
4. **Хамтын оролцоо нь тогтвортой үр дүнд хүргэж байна.** Судалгааны явцад олон нийтийн дунд байгаль хамгааллын талаарх ойлголт, ухамсар сайжирч, өмнө нь оролцдоггүй байсан айл өрхүүд ч хог ангилж эхэлсэн, мод тарьсан, дахин боловсруулалт руу анхаарсан зэрэг тохиолдлууд гарч эхэлсэн нь клубын сурагчид болон багшийн хувьд талархууштай урамтай санагдаж байсан. Зарим өрх өөрсдийн санаачилгаар модны усалгаанд анхаарч, хөрс хамгаалах бордоо хийдэг болсон байна. Энэ бүхнээс харахад сурагчдын үйл ажиллагаа нь нэг удаагийн сурталчилгаа бус, урт хугацааны хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үр дүнтэй болж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт:

Бид байгалийн найзууд эко клубын хүүхдүүд маань цөлжилтөд нөлөөлж буй хүчин зүйлстэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Энэхүү оролцоо нь зөвхөн мод тарих, хог цэвэрлэх зэрэг хувь хүний түвшний үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин илүү өргөн хүрээнд, **нийгэм, бодлогын түвшинд нөлөөлөх боломжтой** гэж дүгнэж байна. Клубын гишүүд цөлжилтийн шалтгаан, үр дагаврын талаар **мэдлэгээ дээшлүүлж, бусдад түгээснээр** олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлнэ. Мөн орон нутгийн байгууллагуудтай хамтран **ойжуулах, нөхөн сэргээх ажилд оролцох, уламжлалт мал маллагааны арга барилыг сурталчлах, малын тоо өсөлтөд биш чанарт илүү анхаарах** зэрэг нь цөлжилтийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулах тал дээр өөрсдийн

дуу хоолойгоо хүргэж, санал санаачилга гарган, бодлого шийдвэрт нөлөөлөх чадвартай иргэд болон төлөвших нь цөлжилт гэх томоохон асуудлыг шийдвэрлэх урт хугацааны тогтвортой шийдэл болно. ЭКО клубын үйл ажиллагаа нь иргэдийн байгаль орчны хандлагыг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Энэхүү жишгийг бодлого тодорхойлогчид, байгаль орчны байгууллагууд бодлого, төлөвлөгөөндөө тусган, тогтвортой санхүүжилт, дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм. Цаашдаа энэхүү туршлагаа бусад сум, сургуулиудад түгээн дэлгэрүүлэх, бүсийн ЭКО клубын зөвлөгөөн зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түлхүүр үг: Эко клуб, сурагчийн манлайлал, иргэдийн оролцоо, байгальд ээлтэй амьдрал, нөлөөллийн ажил, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаа, мод тарих, хог ангилах.

ITS AND 18S RRNA GENE PRIMERS REVEAL DIFFERENT COMMUNITY COMPOSITION AND SIMILAR DIVERSITY PATTERNS ACROSS CLIMATIC GRADIENTS IN MONGOLIAN ARID GRASSLANDS

Uuriintuya Munkhbayar^{1,2,*}, Tulga Enkhjargal², Khishigmaa Batsaikhan¹, and Punsaldulam Dashnyam¹

¹*Institute of Biology, Mongolian Academy of Sciences,*

²*School of Arts and Sciences, National University of Mongolia*

* *Corresponding author: uuriintuyam@mas.ac.mn*

Abstract

Soil fungi play vital ecological functions, including organic matter decomposition, nutrient cycling, and forming symbiotic relationships with plants. These functions sustain soil fertility and underpin ecosystem resilience, particularly in arid and semi-arid regions where fungi help buffer against desertification. Environmental changes can alter fungal diversity and community structure, directly impacting ecosystem functioning. Mongolia, with its wide climatic gradient, offers a natural setting for studying climate-driven shifts in fungal diversity and communities. However, there are limited studies covering the Mongolian soil fungal community and diversity patterns across distinct climatic conditions.

Amplicon sequencing is an effective method for characterising fungal community composition and diversity. However, primer selection could introduce a bias due to varying levels of taxonomic coverage and resolution. In this study, we compared the performance of two commonly used primer sets—targeting the ITS2 region and the 18S rRNA gene—in capturing fungal community composition, diversity, and their relationships with environmental variables, including climate, geography, and soil characteristics.

We collected soil samples from 26 sites across Western and Central Mongolia, selected to capture variations in mean annual precipitation (MAP) and to represent four ecological zones: desert, desert steppe, forest steppe, and forest. At each site, five topsoil samples (0–15 cm depth) were collected using the 5-point diagonal method, resulting in a total of 130 samples. DNA was extracted from sieved (1 mm mesh) using either the DNeasy PowerSoil Pro Kit (Qiagen, Germany) or the CTAB method (for desert samples). The ITS2-2 region was amplified using the fITS7/ITS4 primers, and the 18SV4-1 region using the TAREuk454FWD1/TAREukREV3 primers. Sequencing was performed on the Illumina Novaseq 6000 platform (Guangdong Magigene Biotechnology Co., Ltd, China). The raw paired-end reads were quality filtered with FLASH and Btrim, clustered into OTUs with UPARSE, and assigned taxonomy using

UNITE 8.3 database for ITS dataset (hereafter ITS) and SILVA 138.1 for 18S dataset (hereafter 18S). To account for sequencing depth variability, OTU tables were rarefied prior to diversity analyses. Fungal sequences were manually picked from the 18S dataset and used for the analyses. The rarefied OTU tables were used to calculate taxon relative abundances, alpha diversity metrics (OTU richness and Shannon index), and beta diversity metrics (Bray-Curtis dissimilarity). Statistical analyses were conducted in R (v4.5.2), using the *vegan* package for ecological distance and Mantel tests, *microeco* for microbial community analysis, and *dplyr* and *ggplot2* for data manipulation and visualisation.

The ITS identified *Ascomycota* (91.87%) as the dominant fungal phylum, with lower proportions of *Basidiomycota* (2.99%), *Mucoromycota* (0.08%), and *Chytridiomycota* (0.24%). In contrast, the 18S revealed higher proportions of *Basidiomycota* (18.74%), *Mucoromycota* (14.56%), and *Chytridiomycota* (16.71%), along with *Ascomycota* (21.24%). Thus, *Basidiomycota*, *Mucoromycota* and *Chytridiomycota* were significantly underrepresented in the ITS. Additionally, the 18S contained a higher proportion of unclassified reads (7.28%) compared to ITS (4.02%). Minor phyla, including *Mortierellomycota*, *Chytridiomycota*, and *Mucoromycota*, were detected at low abundance in both datasets, but were more prominent in the 18S compared to ITS. Notably, the ITS detected a higher number of fungal taxa in our study. The higher variability of the ITS region enables species-level resolution but often overrepresents dominant groups such as *Ascomycota*, whereas 18S primers capture broader taxonomic patterns at phylum and class levels but lack species-level detail. Differences in taxonomic representation between the primer pairs introduce further biases, particularly in phylum-level analysis. Some phyla, including *Chytridiomycota* and *Mucoromycota*, which were detected by both primers, showed clear distinct environment dependencies in the 18S dataset, but not in the ITS dataset. Specifically, in the 18S *Chytridiomycota* showed strong positive correlations with MAP and total soil organic matter (SOM), and strong negative correlations with mean annual temperature (MAT) and soil pH. Whereas, in the ITS, this phylum was correlated with only soil pH, indicating that the observed environmental patterns were primer dependent. These discrepancies emphasise the importance of using different primers to obtain a comprehensive profile of fungal communities.

Fungal alpha diversity (OTU richness and Shannon index) showed consistent patterns along climatic gradients. OTU richness was positively associated with MAP, with R^2 values of 0.49 ($p < 0.001$) for the ITS and 0.33 ($p < 0.001$) for the 18S. In contrast, both datasets showed negative associations with MAT, with R^2 values of 0.34 ($p < 0.001$) for ITS and 0.17 ($p < 0.001$) for 18S. These results suggested that more climate-sensitive groups were detected by fITS7/ITS4. The Shannon indices followed similar trends, though the associations were slightly weaker (MAP R^2 = 0.45 and 0.20, in ITS and 18S, respectively; $p < 0.001$, and a negative dependence

with MAT $R^2 = 0.18$ and 0.14 , respectively; $p < 0.001$). Furthermore, we performed Mantel tests to assess the influence of environmental variables on fungal community structure, as represented by the Bray-Curtis dissimilarity index. The results exhibited a similar trend across both ITS and 18S, with community structure showed the strongest relations with MAP and MAT ($p < 0.001$). Then, followed by plant cover, longitude, latitude, soil organic matter (SOM), and soil moisture content (SMC), each showed a significant relation ($p < 0.05$). However, pH was significantly associated with community structure in the ITS dataset ($p < 0.05$), but not in the 18S dataset ($p > 0.05$).

In conclusion, understanding soil fungal diversity is crucial for sustaining soil health and guiding strategies to mitigate desertification in Mongolia's arid ecosystems. Our findings highlight a strong influence of climate (MAP and MAT) on the fungal community in Mongolian soils. Both ITS and 18S rRNA markers provide valuable yet distinct insights into fungal community composition, while capturing similar patterns in the impact of climate variables on diversity and community structure. The ITS primers (fITS7/ITS4) were particularly effective for detecting species richness and resolving fungal community composition at fine taxonomic levels, though they tend to underrepresent certain phyla. In contrast, the 18S primers (TAREuk454FWD1/TAREukREV3) could offer broader taxonomic coverage, but lower taxonomic resolution. The study underscores the complementary nature of different primer sets and contributes important insights into fungal community diversity across environmental gradients.

Keywords: Fungal community composition, fungal alpha diversity, fungal beta diversity, ITS region, 18S rRNA

PRODUCTION OF EXOPOLYSACCHARIDE BY RHIZOBIUM sp. 25a-11 AND ITS POTENTIAL IN PROMOTING SOIL AGGREGATION AND WIND EROSION RESISTANCE

Gerelmaa Zorigtbaatar^{1*}, Anarzul Lhagvadorj², Punsaldulam Dashnyam¹

¹ *Institute of Biology, Mongolian Academy of Science, Ulaanbaatar, Mongolia*

² *School of Arts and Sciences, National University of Mongolia*

* *Corresponding author: Gerelmaaz@mas.ac.mn*

Abstract

Soil is a biologically active and porous medium forming the uppermost layer of the Earth's crust. It plays a critical role in supporting plant growth and maintaining terrestrial ecosystems. Beyond providing physical support for vegetation, soil contributes to ecosystem health by filtering and degrading harmful substances, as well as cycling carbon and essential nutrients. These functions are vital for long-term productivity and environmental sustainability. However, soil degradation and erosion, driven by climate change and intensified human activity, have emerged as major global environmental challenges. Soil degradation poses a critical threat to agricultural productivity, biodiversity, and ecosystem functioning. A major consequence of this process is dust pollution, which not only accelerates land deterioration but also exposes the environment and human populations to toxic elements. Existing mitigation strategies are often constrained by limited effectiveness, sustainability, and environmental safety, underscoring the urgent need for innovative, eco-friendly solutions. In this context, microbial extracellular polysaccharides (EPS), macromolecules secreted by diverse microorganisms, offer considerable potential. Widely recognized for their industrial applications as thickeners, bio-emulsifiers, bio-flocculants, antioxidants, and antimicrobials, EPS are also increasingly valued for their capacity to enhance soil aggregation, improve fertility, and reduce erosion and dust emissions.

This study aimed to (1) isolate EPS-producing bacteria with potential for improving soil properties, including water-holding capacity, wind erosion resistance, and aggregate stability, and to (2) evaluate the effectiveness of EPS-producing bacterial strains and/or extracted EPS in reducing airborne particulate matter generated by wind erosion. Ultimately, we propose the development of a microbial EPS-based soil enhancer and dust suppressant in alignment with the principles of sustainable development.

To accomplish these goals, we collected soil samples from 26 ecologically and climatically diverse sites across Central and Western Mongolia in June 2022, from which 430 EPS-producing bacterial isolates were obtained. Among them, 134 isolates

produced high levels of EPS (500–1100 µg/ml), while 258 isolates produced lower amounts (<500 µg/ml) in the selected medium. 16S rRNA gene sequencing revealed that EPS-producing strains mostly belonged to the genera *Bacillus*, *Paenibacillus*, and *Rhizobium*. Following extensive screening for water-holding capacity, emulsifying activity, flocculating activity, and compositional stability under different cultivation and nutrient conditions, we selected strain *Rhizobium* sp. 25a-11 for further investigation. Its partial 16S rRNA gene sequence shared 98.81% identity with *Rhizobium vallis*. To optimize EPS production, we assessed the metabolic versatility of strain *Rhizobium* sp. 25a-11 using the Biolog EcoPlate™ system, which revealed a broad capacity to utilize diverse carbon sources. The highest substrate utilisation was observed for simple sugars and sugar alcohols, particularly D-mannitol, which led us to select Yeast Mannitol (YM) medium for cultivation. Furthermore, we tested the effect of osmotic stress by adding Polyethylene Glycol (PEG) 8000 to the cultivation medium. The maximum yield of EPS (8.5 g/L) was achieved in YM medium containing 10% (w/v) PEG 8000. This suggests that EPS production may serve a protective role under osmotic stress conditions.

Next, we evaluated the soil-enhancing potential of EPS extracted from *Rhizobium* sp. 25a-11 (hereafter EPS), focusing on its effect on soil aggregation, water retention, and dust suppression. Treatment with 0.25% (w/w) EPS and bacterial supernatant significantly increased the mean weight diameter of soil aggregates, showing a 162.5% improvement over water-treated control. We further assessed the stability of soil aggregates using the ASTM D440 – 86 (Standard Method of Drop Shatter Test for Coal). Soil aggregate stability increased by 4.75 to 6.24 times in EPS-treated samples, indicating substantial improvements in aggregate mechanical integrity. These results indicate that EPS and bacterial supernatant treatments substantially promote aggregate formation and enhance the mechanical integrity of soil aggregates. Furthermore, we evaluated the effect of EPS on soil moisture retention by measuring moisture evaporation from soils treated with EPS solutions at concentrations of 0.5%, 1.0%, 1.5%, and 2.0% w/w, compared to a control treated with distilled water. The 1.0% EPS treatment exhibited the greatest anti-evaporation performance, and further increases in EPS concentration did not show improvements in slowing down the evaporation. The 1.0% EPS-treated soils showed slower and more uniform moisture loss, while the control experienced rapid drying in the initial hours. These results confirm that EPS enhances soil water retention capacity. Finally, we tested the efficacy of EPS in reducing soil erosion and particulate matter (PM) emissions induced by wind (10 m/s) using sandy and clayey soils. EPS-treated samples exhibited 11.32–13.04-fold less soil mass loss than controls. In parallel, airborne particulate matter (PM) concentrations were monitored using the PurpleAir II sensor, a real-time, laser-based air quality monitoring device designed to detect fine particulate pollutants (PM_{1.0}, PM_{2.5}, and PM₁₀). A 0.25% (w/w) EPS application significantly reduced

PM emissions. Specifically, PM_{1.0} concentrations decreased by 2.22–8.84 times, PM_{2.5} by 3.93–6.25 times, and PM_{10.0} by 4.38–6.22 times across all tested samples. We extended these tests to pulverized coal samples, where EPS treatment reduced PM emissions by 4.45-fold relative to water-treated controls. The Drop Shatter Test also showed a 6.5-fold improvement in the stability of coal pellets in EPS treated coal samples compared to the control. These results demonstrate that EPS extracted from *Rhizobium* sp. 25a-11 markedly enhances resistance to wind-induced erosion in soil and coal samples.

